

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр ялган гаргасан болно. Шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг хавсаргав.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	99	427
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хэсэг, заалтын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 23 хуулийн 70 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 22 хуулийн 67 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 2 хуулийн 3 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 22 хуулийн 67 хэсэг, заалтын хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 22 хуулийн 45 хэсэг, заалт буюу 67.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 6 хуулийн 13 хэсэг, заалт буюу 19.4 хувь нь хэрэгжих шатанд, 5 хуулийн 5 хэсэг, заалт буюу 7.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 хуулийн 2 хэсэг, заалт буюу 3 хувь нь хэрэгжээгүй, 2 хуулийн 2 хэсэг, заалт буюу 2.9 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	23	70		100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	22	67		95.7
<i>Үүнээс:</i>				
- бүрэн хэрэгжсэн	22	45		67.2
- хэрэгжих шатанд	6	13		19.4
- хэрэгжилт хангалтгүй	5	5		7.5
- хэрэгжээгүй	2	2		3
- үнэлэх боломжгүй	2	2		2.9

2.3. Мэдээнд гарсан зөрчил

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн хэрэгжилтийн мэдээнд 70 хувь буюу “хэрэгжих шатанд”, 2 хуулийн 2 хэсэг, заалтыг 30 хувьтай буюу “хэрэгжилт хангалтгүй” гэж үнэлэн, хэрэгжилтийн хувь бууруулан ирүүлсэн байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан давхардсан тоогоор 25 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	25	53
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 8 тогтоолын 28 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 5 тогтоолын 17 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 3 тогтоолын 11 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	8	28	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	5	17	60.7
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	4	12	70.6
- Хэрэгжих шатанд	1	4	23.5
- Хэрэгжилт хангалтгүй	1	1	5.9
- Хэрэгжээгүй	-	-	-

- Үнэлэх боломжгүй	-	-	-
--------------------	---	---	---

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 5 тогтоолын 17 заалтаас давхардсан тоогоор 4 тогтоолын 12 заалт буюу 70.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 4 заалт буюу 23.5 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 5.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй мэдээ ирүүлсэн байна.

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын биелэлтийг ирүүлэхдээ 2013-2017 оны эхний хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжиж, хяналтаас хассан 2 тогтоолын 7 заалтыг ирүүлсэн бөгөөд дараах хяналтанд байгаа 3 тогтоолын 11 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Тогтоолын нэр, огноо	Заалт	Заалтын агуулга
1	Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2014.01.16 №17	1.1	Монгол судлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Монгол судлалын үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулах;
		1.2	Монголын түүх, нийгэм, соёл, хэл, зан заншил, үндэсний баялаг өв сангаа судлах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, хилийн чанадад болон дотоодод монгол судлалыг тогтвортой хөгжүүлэхэд Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлж, холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталж мөрдүүлэх;
		1.3	Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг Монгол судлалыг дэмжих сангийн чиг үүрэгтэй уялдуулж, Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах;
		1.4	Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт бүрэн тусгаж байх.
2	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай 2015.01.29 №12	2.1	“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлэх.
3	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019.05.30 №53	1/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хоол зүйчийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн бэлтгэх, төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн эмчийг хөрвөх сургалтад хамруулан 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хүний нөөц бүрэн бэлтгэгдэх хүртэлх хугацаанд сургуулийн хоол зүйчээр ажиллуулах ажлыг зохион байгуулах;
		2/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны, дунд ангийн суралцагчдыг 2022-2023 оны, ахлах ангийн суралцагчдыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн хамруулах;
		5/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн

		шим тэжээлийн хэрэгцээг харгалзан Монгол Улсын Засгийн газраас жил тутам шинэчлэн батлах;
	6/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.12-т заасан хандив, тусламжийг хүлээн авах ажлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
	7/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байрын түрээсийн гэрээг харилцан тохиролцож дуусгавар болгох ажлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
	8/	энэ тогтоолыг баталсантай холбогдуулан сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар батлах.
Нийт 3 тогтоолын 11 заалт		

ДӨРӨВ. БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтанд байх заалтууд байна. Давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420
	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Энэ удаа хэрэгжилтийн мэдээнд өмнөх онуудад хяналтаас хасагдсан заалтын мэдээг давтан ирүүлээгүй нь сайшаалтай байна.

4.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 21 тогтоолын 184 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналтад байгаа тус Байнгын хорооны 19 тогтоолын 93 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 14 тогтоолын 91 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 19 тогтоолын 93 заалтаас давхардсан тоогоор 16 тогтоолын 65 заалт буюу 69.8 хувь нь бүрэн хэрэгжсэн, 9 тогтоолын 16 заалт буюу 17.2 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 1.1 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 4 тогтоолын 6 заалт буюу 6.5 хувь нь хэрэгжээгүй, 4 тогтоолын 5 заалт буюу 5.4 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй мэдээ ирүүлсэн байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	НББСШУБХ-ны	Заалт	
	ТОГТООЛ /давхардсан тоогоор/	Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	21	184	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	19	93	50.5
<i>Үүнээс:</i>			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	16	65	69.8
- <i>Хэрэгжих шатанд</i>	6	16	17.2
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	1.1
- <i>Хэрэгжээгүй</i>	4	6	6.5
- <i>Үнэлэх боломжгүй</i>	4	5	5.4

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа 21 тогтоолын 184 заалтаас 14 тогтоолын 91 заалт буюу 49.5 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооноос гарсан тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал;

№	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	“Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” /2013.04.16 №04/04/	1.5/, 1.6/, 1.7/ дахь заалт;
2	“Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2014.04.23 №07/	1.5/, 1.9/ дэх заалт;
3	“Эмнэлгийн барилга, эзэмшил газрын талаар цаашид авах арга хэмжээний тухай” /2014.05.13 №09/	2 дахь заалт;
4	“Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан	3.1/ дэх заалт;

	сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” 2016.04.05 №10/	
5	“Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” /2016.12.14 №04/	2.1/, 2.2/ дахь заалт;
6	“Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай” /2017.02.16 №17/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.6/, 1.7/, 1.8/, 1.9/ дэх заалт;
7	“Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2017.02.16 №18/	2.1/, 2.2/, 2.3/, 3.1/, 3.2/, 3.4/, 3.5/, 3.6/, 3.7/, 4, 5, 6, 7 дахь заалт;
8	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” /2017.06.09 №24/	1.1/, 1.2/, 1.3/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 1.9/, 1.10/, 1.11/, 1.12/, 1.13/, 1.14/, 1.15/, 2, 3 дахь заалт;
9	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” /2017.07.05 №25/	1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 1.10/, 1.11/, 2, 3 дахь заалт;
10	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” /2017.07.05 №26/	1.а.1/, 1.а.2/, 1.а.3/, 1.а.4/, 1.а.5/, 1.б.1/, 1.б.2/, 1.б.4/, 1.б.5/, 1.б.6/, 1.б.7/, 1.б.8/, 1.в.1/, 1.в.2/, 1.в.3/, 1.в.4/, 1.в.5/, 1.г.1/, 1.г.2/, 3 дахь заалт;
11	“Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2018.05.15 №13/	1.1/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт;
12	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” /2018.05.22 №14/	3 дахь заалт;
13	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” /2018.06.22 №17/	2, 3 дахь заалт;
14	“Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2018.10.16 №21/	1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 1.9/, 1.10/, 2 дахь заалт;

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 21 хуулийн 37 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 45 тогтоолын 103 заалт, Байнгын хорооны 16 тогтоолын 61 заалтыг хяналтаас хасах саналтай ирүүлснийг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1. 2019 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг өмнөх онуудтай харьцуулахад өндөр хувьтай ирүүлсэн боловч 100 хувьтай буюу “бүрэн хэрэгжсэн” заалтын хэрэгжилтийг дутуу тайлагнан ирүүлснээс бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай гэж үзэхэд хүндрэлтэй байгааг цаашид анхаарах.

2. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилтийн хувь хэмжээг өмнөх оноос бууруулж ирүүлэх, түүний шалтгаан нөхцөлийг тодорхой нарийвчлан тайлагнаж ирүүлэхгүй байх дутагдалтай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ 2014.05.15	40.4. Зөрчлийн тухай мэдээллийг худалдан авах журмыг Засгийн газар батална. Мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн дагуу чандлан хадгална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А-297, 360 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-т “Эрэн сурвалжлагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, бусад эд зүйлсийн тухай мэдээлэл”-ийг 2 сая хүртэл төгрөгөөр худалдан авахаар тусгасан. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 40.4 дэх заалтыг хасах саналыг оруулан, Соёлын тухай шинэчилсэн найруулгын төсөлтэй Улсын Их Хуралд өргөн барьсан.
		52.2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг соёлын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2019 оны А/237/92 дугаар тушаалаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам батлагдсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2019 оны А/237, А/92 дугаар тушаалаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам-ыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2	Номын сангийн тухай 2014.12.19	24.3. Хувийн номын сангийн сан хөмрөгт чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл байгаа тохиолдолд тухайн номын санд дэмжлэг үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БСШУС-ын сайдын 2020 оны А/158 дугаар тушаалаар “Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл хадгалагдаж байгаа хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам”-ыг батлуулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн хууль тогтоомжийн нэгдсэн мэдээллийн www.legalinfo.mn цахим санд байршууллаа.
3	Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015.01.29	20.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	"Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/591 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар батлагдсан. Батлагдсан маягтын дагуу тайлан мэдээг гаргаж байна. Үүнд: 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тайлангийн хавсралт-ЭМД 11 /ТҮ-ний төрөл/ 2. ЭМДС-аас санхүүжүүлсэн ... оны тусламж, үйлчилгээний зардал /аймаг, нийслэл/, 3. ЭМДС-аас эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн нэгтгэл, 4. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын ... дугаар улирлын байдлаар тооцоо нийлсэн актын нэгтгэл, 5. Аймаг/Нийслэлийн гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын ... дугаар сарын тусламж, үйлчилгээний төлбөрийн гүйцэтгэл".

			2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь уг маягтын загварыг хамтран батлахаар шийдвэрлэсэн. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс ЭМДС-гийн анхан шатны нягтлан бодох бүртгэлийн маягтыг батлуулахаар ирүүлсэн нь нягтлан бодох бүртгэлд хамаарах маягт биш байсан тул хуулиар олгосон эрхийн дагуу уг маягтыг Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 2019 оны 9 дүгээр сард дангаар баталсан болно. Харин Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг баталсан бөгөөд уг маягтыг ЭМДС мөрдөж, нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж байна.
4	Нийгмийн даатгалын тухай 1997.05.31	15.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 2.8 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг 0.8, 1.8, 2.8 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалтыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.
5	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай 1994.07.05	6.3. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална. Энэ хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 22 дугаар тогтоолоор “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”-ыг шинэчлэн баталсан.
6	Эрүүл ахуйн тухай 2016.02.04	7.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийг холбогдох хяналтын байгууллага батална.	Үйлдвэр үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн нэр бүхий 7 дүрмийг боловсруулан МХЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 3862 дугаарт бүртгүүлэн ажиллалаа. Үүнд:

			<p>1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>2.“Хүнсний худалдааны газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>3.Хүнсний үйлдвэрт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>4.Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>5.Үсчин, гоо сайхны газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>6.Зочид буудал, жуулчны бааз, амралтын газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм;</p> <p>7.Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтэлийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм.</p>
7	Хүүхдийн эрхийн тухай 2016.02.05	12.1.3. хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;	<p>Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлуулж, тус хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ХТҮЗ-ийг арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий Хүүхдийн хөгжил хамгааллын салбар дундын бүлгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар байгуулж, ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн 2 дугаар шатны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хамтарсан тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Цахим орчинд бага насны хүүхдийг цахим гадуурхал, хортой буюу хориотой контентоос хамгаалах, дэлгэцийн хэт хамаарлаас сэргийлэх зорилготой "Цахим орчинд хүүхэд хамгаалахад баримтлах чиглэл"-ийг 2020 оны 4 дүгээр сард батлав.</p>
8	Хүүхдийн хамгааллын тухай 2016.02.05	13.3. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ Нийтлэг шаардлага, MNS 6517:2017 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар батлуулсан. Тус стандартыг хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн сургалтыг зохион байгуулж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээг МХЕГ, ЦЕГ, ОБЕГ-тай хамтран жил бүр зохион байгуулж хэвшсэн. 2019 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар 31 асрамж халамжийн төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Стандартын хэрэгжилтийн хувь 96 хувьтай байна.</p> <p>Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулах журмын төслийг боловсруулсан ба Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд асрамжийн үйлчилгээ, түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, асралт гэр бүлийн үйлчилгээний зардал, зохицуулалтын талаар, Гэр бүлийн тухай хуулийн нэмэлт</p>

			<p>өөрчлөлтийн төсөлд хүүхэд асрах үйлчилгээний зохицуулалтын талаар тусгасан. Эдгээр хуулиуд хүчин төгөлдөр болсноор хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг зохицуулах эрх зүйн орчин бүрдэх юм.</p> <p>Улсын хэмжээнд 21 байгууллагын 31 асрамж халамжийн төв үйл ажиллагаа явуулж “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт”-ыг өдөр тутмын ажилдаа мөрдөн ажиллаж байна.</p>
9	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016-02-05</p>	<p>13.2. Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.</p>	<p>Брайль үсгийн стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжил зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүл мэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэн 2019 оны СХЗГ-ын даргын С/58 тоот тушаалаар “Монгол брайль бичгийн стандарт” MNS6800:2019 батлагдсан.</p> <p>Энэ стандарт батлагдсанаар хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс харааны бэрхшээлтэй иргэдтэй брайль үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэж, харилцааны чухал хэрэглүүр болох юм.</p> <p>Багш нарт брайль үсгийн анхан шатны мэдлэг олгох, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бичиг үсэг тайлагдаагүй харааны бэрхшээлтэй хүнд бичиг үсэг заах зэрэг ажлуудыг хэрэгжүүлнэ.</p> <p>2019-2020 оны хичээлийн жилд 116 дугаар сургуулийн сурагчдад өндөржүүлсэн бэлэн байдлын үед онлайн хичээл явуулах зааварчилгаа, унших сэдвүүд, гарын авлагыг шинэ стандартын дагуу брайль үсгээр хэвлэн сурагчдад хүртээл болгосон.</p>
		<p>23.4. Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/07 дугаар тушаалаар батлуулаад байна</p>
10	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016-04-22</p>	<p>13.5. Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/196 дугаар тушаалаар байгуулагдсан 21 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг "Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам" болон "Сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт"-ыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/502 дугаар тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p>
		<p>21.2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиник нь энэ хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч</p>	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дах хэсэгт заасан тусламж үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцахаар баталсан бөгөөд энэ тусламж үйлчилгээг өртөг ойролцоо оношийн бүлгээр санхүүжүүлэхээр холбогдох тооцоо, судалгааг Сангийн яам, төслийн багтай хамтран 2019 оны 12 сард зохион байгуулж дууссан. Судалгаа, тооцоололд үндэслэн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019</p>

		гүйцэтгэх бөгөөд санхүүжилт авах журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 256/А/561 дүгээр “Улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, өртгийн жин, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, хяналт тавих журам батлах тухай” тушаал батлагдсан. Энэхүү журмын хүрээнд Төсвийн санхүүжилтийг 2020 оноос эхлэн өртөг ойролцоо оношийн бүргээр санхүүжүүлэхээр 3 /Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Арьсны өвчин судлалын үндэсний төв/ эмнэлгийг бие даалган үйл ажиллагаа явуулахаар төсвийг батлуулсан. Мөн Сангийн яамны дэргэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах төслийн нэгжтэй хамтран цаашид хийх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.
		22.3. Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/226 тушаалаар "Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4775 дугаарт бүртгүүлэв.
11	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2017.01.26	6.5. Насны хишиг олгох журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ахмад настнуудад Насны хишиг тэтгэмж олгох зорилтыг хэрэгжүүлэн Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Насны хишиг олгох журам”-ыг батлуулж 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Ахмад настнуудын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, орлогын баталгааг бууруулахгүй байх зорилгоор 65 ба түүнээс дээш настай ахмад настнуудад Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сар, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын дараах насны иргэнд доор дурдсан хэмжээгээр насны хишгийг жилд хоёр удаа 4 дэх жилдээ олгож байна. Үүнд: 65-69 настай ахмад настанд 50.0000 төгрөг; 70-79 настай ахмад настанд 80.000 төгрөг; 80-89 настай ахмад настанд 150.000 төгрөг; 90 ба түүнээс дээш настай ахмад настанд 250.000 төгрөгийг тус тус олгож байна. Насны хишиг тэтгэмжийн хамрах хүрээ, ахмадуудын нас дэвших байдлыг харгалзан жил бүр шаардагдах хөрөнгийг улсын төсөвт нэмж тусган батлуулж, тэтгэмж олгох ажлыг ахмадуудад хүндрэл чирэгдэлгүй зохион байгуулж байна. 2020 онд Насны хишиг тэтгэмжид зориулан 22,3 тэрбум төгрөгийг батлан Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын олголтоор 135 мянган ахмадад 11,0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгоод байгаа бөгөөд Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан 6 дугаар сард олгоно.
12	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2016.11.10	13.11. Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд	Нийгмийн халамжийн тухай хуульд байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасны дагуу “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч байгаа иргэнийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт”-ийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02 дугаар сарын 28-ны

		хамтран батална. /13.2.4.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.	өдрийн А/69/48 дугаар хамтарсан тушаалаар батлан 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Өвчин гэмтлийн жагсаалт батлагдснаар аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч нар байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлоход нэгмөр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичигтэй болж, асаргаа шаардлагатай иргэнийг үнэн зөв тогтоох, улмаар асаргааны тэтгэмжид зарцуулах хөрөнгийг үр ашигтай болгох, халамж хүрэх ёстой иргэндээ хүрэхэд чухал алхам болсон. Уг тушаал нь байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчний 9 бүлэг, 77 онош, 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох жагсаалт нь өвчний 14 бүлэг, 64 оноштой, иргэний өөртөө үйлчлэх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хуудас болон асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох заавраас бүрдэж байна Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай” А/69, 48 дугаар хамтарсан тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг батлан хэрэгжүүлж байна.
		13.12. Энэ хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам” -ыг баталсан.
13	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2016.11.10	42.3. “Төсвийн байгууллагаас энэ хуулийн 42.1-д заасан нэг удаагийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан нийтлэг журмыг Засгийн газар батална. /42.1.Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно./	УИХ-аас 2017 онд баталсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 62 дугаар зүйл болон “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 7 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, 6 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ыг тус тус батлан мөрдөж байна.
14	Ахмад настны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.01.26	8.3. Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ.	2018 оны 16 дугаар тогтоолоор тэтгэврийг 21,000 төгрөгөөр нэмсэн. 2019, 2020 оны төсөвт мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн төвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн.

	<p>9.7. Энэ хуулийн 9.1.1, 9.3, 9.4-т заасан мэдээллийн санг удирдах, ашиглах журмыг Засгийн газар батална.</p> <p>/9.1.1.хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахмад настныг бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэх; 9.3.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн салбарт зөвлөх мэргэжилтнээр ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг төрийн бодлого, хууль тогтоомж боловсруулах, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх ажилд оролцуулах арга хэмжээ авна.</p> <p>9.4.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэсний хэмжээнд ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг мэргэжлийн чиглэлээр нь сургагч багшаар бэлтгэх, зөвлөх үйлчилгээнд зуучлах ажлыг зохион байгуулна./</p>	<p>Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оноос одоог хүртэл Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт</p> <ul style="list-style-type: none"> • 2017 онд 2,278 ахмад хамрагдаж, 1,3 тэрбум төгрөг зарцуулж, 2,316 ажлын байр бий болсон. • 2018 онд 1,527 ахмад хамрагдаж, 1,1 тэрбум төгрөг зарцуулж, 1,561 ажлын байр бий болсон. • 2019 онд 1,342 ахмад хамрагдаж, 1,2 тэрбум төгрөг зарцуулж, 1,285 ажлын байр тус тус бий болсон байна.
	<p>11.1.1. өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх хөтөлбөрийг Засгийн газар баталж, хэрэгжүүлэх;</p>	<p>Ахмад настны тухай хуулийн 11.1.1-д “өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх хөтөлбөрийг Засгийн газар баталж, хэрэгжүүлэх” гэж заасныг үндэслэн “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/47 дугаар тушаалаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах; ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх; ахмад настны чадамжийг дэмжих; ахмад настны амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах гэсэн 4 зорилтын хүрээнд 58 үйл ажиллагааг 2020-2023 онуудад хэрэгжүүлнэ.</p> <p>Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, ахмад ажилтныг сэтгэл зүй, нийгэм, эдийн засгийн хувьд тэтгэвэр бэлтгэх, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын</p>

		ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг уялдуулан хэрэгжүүлэх боломжоор хангагдах юм.
	12.2. 65 болон түүнээс дээш настай ахмад настанд Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан жил бүрийн 01 дүгээр сард, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан жил бүрийн 7 дугаар сард улсын төсвөөс санхүүжүүлэн насны хишиг олгох бөгөөд насны хишиг олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Насны хишиг олгох журам”-ыг батлуулж 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Ахмад настнуудын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, орлогын баталгааг бууруулахгүй байх зорилгоор 65 ба түүнээс дээш настай ахмад настнуудад Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сар, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын дараах насны иргэнд доор дурдсан хэмжээгээр насны хишигийг жилд хоёр удаа 4 дэх жилдээ олгож байна. Үүнд: 65-69 настай ахмад настанд 50.0000 төгрөг; 70-79 настай ахмад настанд 80.000 төгрөг; 80-89 настай ахмад настанд 150.000 төгрөг; 90 ба түүнээс дээш настай ахмад настанд 250.000 төгрөгийг тус тус олгож байна. Насны хишиг тэтгэмжийн хамрах хүрээ, ахмадуудын нас дэвших байдлыг харгалзан жил бүр шаардагдах хөрөнгийг улсын төсөвт нэмж тусган батлуулж, тэтгэмж олгох ажлыг ахмадуудад хүндрэл чирэгдэлгүй зохион байгуулж байна.
	13.2. Энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт /АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭМЖЛЭГ, ХҮНДЭТГЭЛ/ заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэлийн хэмжээ, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.	Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах” тухай Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ыг баталсан. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх хэмжээг жилд 2 удаа тус бүр 10,000 төгрөгөөр Засгийн газрын тогтоолоор батлан Ахмадын өдөр болон Цагаан сарын шинийн 1-нд хүндэтгэл үзүүлж байна.
	14.7. Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална. /14.6-д Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ./	Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг баталсан. Ахмадын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ. 1.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлийн саналыг үндэслэн өөрийн төсөв, жил бүрийн үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулна. Ахмадын санг дараах арга хэмжээнд зарцуулна. 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна: 3.1.1. байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох; 3.1.2. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах; 3.1.3. нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх; 3.1.4. хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; 3.1.5. шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;

			<p>3.1.6. эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх;</p> <p>3.1.7. ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;</p> <p>3.1.8. ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>3.1.9. амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангүй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж үзүүлэх.</p>
15	<p>Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.01.26</p>	<p>6.3. Энэ хуулийн 5.4-д заасан хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална. /5.4-д Энэ хуулийн 4.1-д заасан ахмад настанд доор дурдсан хөнгөлөлтийг үзүүлнэ: 5.4.1.нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардалд жилд нэг удаа; 5.4.2.дотоодын рашаан сувиллын эрхийн бичгийн үнэ, ирэх, буцах замын зардалд жилд нэг удаа нөхөн; 5.4.3.орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулж жилд нэг удаа./</p>	<p>УИХ-аас 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Ахмад настны тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг баталсан.</p> <p>Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-д алдар цолтон ахмад настанд нийгмийн халамжийн сангаас үзүүлэх 3 төрлийн хөнгөлөлтийг олгохтой холбоотой зохицуулалтыг тусган мөрдөж байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017.02.02-ны өдрийн хуралдаан Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.</p> <p>Энэхүү хуулийн хүрээнд ахмад настан дараах үйлчилгээнд хамрагдах боломжтой Үүнд:</p> <p>Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлтөнд хамрагдана.</p> <p>Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд сар бүр мөнгөн тусламж /200,000 төгрөг/ ахмад дайчин, дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т сар бүр мөнгөн тусламж; /200,000төгрөг/ Монгол Улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, түүнчлэн Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүнд сар бүр мөнгөн тусламж /150,000 төгрөг/ нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардалд жилд нэг удаа; /нийтийн тээврийн тарифт зардлаар тооцож олгоно./ дотоодын рашаан сувиллын эрхийн бичгийн үнэ, ирэх, буцах замын зардалд жилд нэг удаа нөхөн; /14 хоног хүртэл амрана, эрхийн бичгийн үнийг энгийн өрөөний тарифаар, тээврийн хэрэгслийн нэг талийн зардлыг орон нутгийн нийтийн тээврийн тарифт</p>

			зардлаар тооцож олгоно./ орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулж жилд нэг удаа. /140,000 төгрөг/
16	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017.05.12	14.2.3. энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, зааврыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх.	Ажлын хэсгийн гишүүдийн хурлыг нийт 5 удаа хийсэн. Журмын төслийн хувилбарыг боловсруулсан. Төслийг хүүхдийн хүнс импортлогч аж ахуйн нэгжийн төлөөллүүд болон Монголын сүү үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн төлөөллүүдэд танилцуулж, тэдний саналыг тусгасан. Журмын төслийн яамны веб хуудаст олон нийтээс санал авах зорилгоор нийтэд нээлттэй байдлаар байршуулсан. Хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, 06 дугаар сарын 20-ны өдөр тус тус ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжүүлсэн. ХХААХҮЯ-тай хамтран батлах боломжгүй нь ХХААХҮЯ-аас ирүүлсэн албан бичиг болон уг яамны төлөөлөлтэй хийсэн уулзалтын явцад тодорхой болсон тул журмыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Журам, зааврыг батлах тухай” А/328 дугаар тушаалаар батлуулсан. Эрүүл мэндийн сайдын баталсан энэхүү журмыг ХЗДХЯ-нд хүргүүлж нийтээр дагаж мөрдөх акт болгон бүртгүүлсэн.
17	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18	8.5. Энэ хуулийн 8.1.4-т заасан бүтээлийг сонгон шалгаруулах журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. /8.4.1-т залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай утга зохиол, уран сайхны бүтээлийг дэмжих/ 18.1.3. залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх; 20.2. Энэ хуулийн 20.1.4-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн	“Утга зохиол, уран сайхны бүтээл шалгаруулах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/129 тоот тушаалаар батлууллаа. Журмыг хэрэгжүүлснээр залуучуудад хүрэх медиа контент баяжих, агуулга нь залуучуудын хэрэгцээ шаардлагад илүү нийцэх бөгөөд ингэснээр залуучууд медиа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын талаар системтэй, ач холбогдолтой, бодит дүр зурагтай нийцэхүйц, цаашдын хөгжил төлөвшилд эерэгээр нөлөөлөхүйц мэдээлэл, бүтээлийг хүлээж авах, төлөвших ач холбогдолтой юм. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.6 дах хэсэгт заасны дагуу шалгаруулсан бүтээлийг Залуучуудын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлнэ. Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэгт тусгасан -ы дагуу зарим орон нутагт өөрийн хөрөнгө, боломж нөөцөөр залуучуудын хөгжлийг дэмжих зарим арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газар болон ТББ-ууд хамтран залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, залуучуудын нийгмийн хамгааллыг нэмэгдүүлж, эрүүл мэндийг сайжруулах, хөдөлмөрт бэлтгэх, дадлагажуулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд 2019 оны эхний 3 улиралд 18 ажил арга хэмжээнд 103 сая төгрөгийг орон нутгийн Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлэн зарцуулж 1500 орчим хүүхэд, 8900 орчим залуучуудыг хамруулсан үр дүнтэй байна. Үндэсний статистикийн хорооноос “Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал”-ыг баталсантай холбогдуулан “Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх журам”-ыг Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хүүхэд,

		<p>захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага хамтран батална /20.1.4-т залуучуудын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх/</p>	<p>залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар А/95, А171, А/681 дүгээр хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг 8 бүлгийн 129 үзүүлэлтийн дагуу 16 маягтаар залуучуудын 2018 оны тоон мэдээллийг бүх аймаг, дүүргээс авч нэгтгээд байна.</p>
		<p>20.4. Энэ хуулийн 20.3-т заасан залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. /20.3-т Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна./</p>	<p>Аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн дүрмийг ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/137 дугаар тушаалаар шинэчлэн баталж мөрдөж байна.</p> <p>Залуучуудын хөгжлийн төв бүх аймаг, дүүрэгт байгуулагдаж, амьдрах ухаан, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийн бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг залуучуудад хүргэхээс гадна залуучуудын зөвлөл, сонирхлын клуб, дэмжих бүлэг зэргийг идэвхтэй ажиллуулж байна. Залуучуудад чиглэсэн олон төрлийн үйлчилгээг орон нутгийн түвшинд хүргэхээс гадна залуучууд дуу хоолойгоо нэгтгэх, эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөх аливаа бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт, орон нутгийн төсвийн хуваарилалт зэрэгт санал тусгах боломжийг бүрдүүлээд байна. Эдгээр төвүүд 2017-2019 онд нийт залуучуудын дунджаар 35-40 хувьд хүрч үйлчлэхээс гадна төвийн дүрэмд заагаагүй 270 орчим үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж, 90 гаруй мянган залуучуудыг хамруулж байна. Эдгээр төвүүдэд нийт 99 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа бөгөөд цалин, нийгмийн даатгалын шимтгэлд жилд 750 орчим сая төгрөгийг төсөвлөн зарцуулж байна.</p>
		<p>22.3. Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн салбар зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.</p>	<p>Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газрын 2018 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар, салбар зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Залуучуудтай холбогдох асуудлаар шийдвэр гаргах, үүнд залуучуудын оролцоог хангах зорилгоор аймаг, дүүрэг, сум, хороодод Залуучуудын хөгжлийн 330 гаруй Салбар зөвлөлийг байгуулаад байна. Эдгээр салбар зөвлөлийг аймаг, дүүргийн Засаг дарга ахалж, төрийн, иргэний нийгмийн, залуучуудын байгууллагын төлөөлөл 15-17 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Салбар зөвлөлүүд залуучуудын эрх, хөгжил, хамгааллыг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангадаг.</p> <p>Орон нутгийн залуучууд салбар зөвлөл дэх төлөөллөөр уламжлах замаар залуучуудын хөгжлийг дэмжих аливаа шийдвэр, хэрэгжилтэд оролцох, хяналт тавих бүрэн боломжтой. Салбар зөвлөлүүд 2019 онд 1-2 удаа хуралдаж, 229 шийдвэрийг гаргасан бөгөөд шийдвэрийн хэрэгжилт 90 хувьтай байна.</p>
<p>18</p>	<p>Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай /Шинэчилсэн найруулга/</p>	<p>7.1. Энэ хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-т заасан тэтгэмжийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>/5.1.1.жирэмсэн эхийн тэтгэмж;/5.1.2. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж;/5.1.3.ихэр хүүхдийн тэтгэмж;/</p>	<p>3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай” хуулийн төслийг Засгийн газраас 2016 оны 12 дугаар сарын 28-нд УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p> <p>Энэ хуулийн хүрээнд өрх толгойлсон эцэг эхэд улирал бүр тэтгэмж олгохоос гадна дагалдуулан өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өрх толгойлсон эцэг, эхтэй ядуу өрхийн хүүхдэд дүрэмт</p>

	2017.06.30		хувцас олгох, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийг ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийг нь өдрийн үйлчилгээнд хамруулах асуудлыг тусгасан. Хуулийн хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор журмыг баталсан. Үүний дагуу жирэмсэн эхийн тэтгэмжийг жирэмсний 5 сартайгаас эхлэн төрөх хүртэлх хугацаанд сар бүр 40.0 мянган төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр 50.0 мянган төгрөг, түүнчлэн хоёр ихэр хүүхдэд нэг удаа хүүхэд бүрд 1.0 сая төгрөг, 3 ба түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд бүрд 3.0 сая төгрөг, гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улиралд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгож байна.
19	Биеийн тамирын спортын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.07.06	16.1. Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БСШУС-ын сайдын 2018 оны А/839 дүгээр тушаалаар “Спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журам”-ыг батлуулсан.
20	Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ 2018.01.09	18.7. Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 19.1. Донороос цус, эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, шилжүүлэн суулгах, устгах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" А/500 дугаар тушаалаар Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах болон тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журмуудыг, үр шилжүүлэх суулгах эмчилгээнд тээгч эх ашиглах талуудын хооронд байгуулах гэрээний загвар тус тус батлагдсан. Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" А/504 дүгээр тушаалаар донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг болон амьд донорын зөвшөөрлийн хуудас, амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас, реципиентийн зөвшөөрлийн хуудас тус тус батлагдсан.
21	Багшийн хөгжлийг дэмжих тухай 2018.06.27	8.3. Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын Засгийн газрын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4.1.5 дах заалтыг “Төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь хичээлийн жилийн эхний улиралд; суралцагч 3.0 болон түүнээс дээш голч оноотой

		суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь” олгоно гэж өөрчлөн найруулсан.
	9.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	БСШУС-ын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/812 дугаар тушаалаар “Мэргэжлийн зэрэг олгох, хасах” журмыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох зохицуулалтыг хийсэн. Энэхүү журмаар ЕБС-ийн захиралд мэргэжлийн зэргийг шинээр олгох боллоо. “Тогтвортой хөгжил ба ба Ерөнхий боловсрол 2018” улсын зөвлөгөөний үед гарсан саналыг үндэслэн захирал нарт тэргүүлэх ба зөвлөх багш мэргэжлийн зэрэгтэй болох боломжийг олгосон нь тэдний ажил гүйцэтгэлд тавих шаардлагыг өндөржүүлэх нэгэн хөшүүрэг болно хэмээн үзэж байгаа.
	11.3. Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2019 оны 24-р тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэн баталсан ба төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: Багш нарын цалингийн ангилал, зэрэглэлийг өөрчилж 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлсэн, Албан хаагчдын цалинг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн 8 нэмэгдүүлсэн, Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тогтоохдоо доод жишгийг баталдаг байсан бол тухайн шийдвэрээр цалингийн сүлжээг баталсан. Тус арга хэмжээнд салбарын батлагдсан төсвийн хүрээнд нийт 73177 албан хаагч хамрагдсан байна. Ингэснээр 2018 оны 9 сартай харьцуулахад цэцэрлэгийн багшийн үндсэн цалин 162,272 төгрөгөөр, бага ангийн багшийн үндсэн цалин 95,460 төгрөгөөр, дунд, ахлах ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйчийн үндсэн цалин 119,069 төгрөгөөр, дотуур байрны багшийн үндсэн цалин 118,388 төгрөгөөр, цэцэрлэгийн туслах багшийн үндсэн цалин 96,838 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
	Нийт 21 хуулийн 37 хэсэг, заалт	

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.02.07 №20</p>	<p>1.1. Улсын Их Хурлын даргын 2012 оны 103 дугаар захирамжаар байгуулсан барилгын тухай, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон барилгын тухай хууль тогтоомж, стандарт, норм ба дүрэм зөрчсөн, түүнчлэн зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох этгээдийг нийтэд мэдээлэх, тэдгээрт хариуцлага тооцох;</p> <p>1.3. Барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн тоог цөөрүүлж, тусгай зөвшөөрөл олгох асуудлыг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлэх;</p>	<p>А. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар: 1. “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай” зөвлөмж боловсруулан Барилга, хот байгуулалт, Зам, тээврийн хөгжлийн сайдад 2020.02.19-ний 02/438 тоотой, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2020.02.18-ны өдрийн 02/455 тоотой, аймаг нийслэлийн тус тус хүргүүлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. 2. 2020 оны 3-р сараас нийслэлд барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 384 аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль дүрмийг хэрэгжүүлэн ажиллаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг хэрэгжүүлэх, шинэ хандлага, арга барилыг нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх Мэдээлэл, Зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөт шалгалтаар 102 заалттай 24 албан даалгавар гарган хүргүүлж, прокурорын тогтоолоор 3 байгууллагын үйл ажиллагааг актаар зогсоож, 5 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн хэрэг үүсгэж, 27 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 37 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.</p> <p>Б. Барилгын аюулгүй ажиллагааны талаар: 1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20 аймагт баригдсан 247, Нийслэлийн хэмжээнд баригдсан 43 барилга байгууламжид хяналт шалгалт хийгдсэн бөгөөд эдгээрээс ашиглалтад орсон-62, ажил нь 30-85%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа -95, тендерийн шатанд, маргаантай-23, тодорхой бус шалтгаанаар үйл ажиллагаа явагдаагүй, ажил эхлээгүй-18 байна. Шалгалтаар барилгын тухай хууль тогтоомж, норм ба дүрэм, стандартыг зөрчсөн нийт 626 зөрчлийг илрүүлж, 393 зөрчлийг арилгуулсан бөгөөд нийтдээ улсын /ахлах/ байцаагчийн 13 дүгнэлт, 62 албан шаардлага, 22 зөвлөмж, 5 барилга байгууламжийн угсралтыг түр зогсоох акт үйлдэж, 1 актыг сэргээж, холбогдох байгууллагуудад хүргүүлж, 9 шийтгэлээр 36 сая төгрөгийн торгууль ногдуулж, 23 сая төгрөгийг барагдуулж ажилласан.</p> <p>Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.15-д заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх чиг үүргийг тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт зааснаар, 34.1.14-т заасан тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг 34.2-т зааснаар Монголын барилгын үндэсний ассоциацид, 34.1.15-д заасан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд хамаарах барилгын материалын үйлдвэрлэлийн чанарыг хянан баталгаажуулах</p>

		<p>асуудлыг 34.2-т зааснаар Барилгын хөгжлийн төвд тус тус шилжүүлсэн. “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” гэрээг Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-тай 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. /гэрээг 2019.02.02-нд 2019/30 дугаартай шинэчлэн баталсан./ ТББ тусгай зөвшөөрөл олгох нэг цэгийн үйлчилгээг эрхэлж байна.</p>
	<p>1.8. Аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын таван хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтөөр аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хувь хэмжээг нэмэгдүүлж, төсвийн байгууллага жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас доошгүй, аж ахуйн нэгж, байгууллага ажил, үйлчилгээний нийт зардлын 1,5 хувиас доошгүй хөрөнгийг ХАБЭА болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар тусгасан.</p>
	<p>1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг олон улс, бүс нутгийн түвшинд хүргэж шинэчлэх, санхүүжилтийн асуудлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг боловсруулах, батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулж байхаар хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зохицуулсан. Үүнтэй холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/166 тоот тушаалаар “Зарим стандартыг шинэчлэн боловсруулах” тухай ажлын хэсэг байгуулагдан ажиллаж дараах 4 стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажлын байрны агаараас асбестын сорьц цуглуулах, түүний ширхэглэгийг гэрлийн үе шатаар ялган дүйх микроскопоор(PCM)тоолж, шинжлэх аргын стандарт 2. Ажлын байрны агаараас асбестын сорьц цуглуулах, цахилгаан микроскопын (TEM) аргаар түүний төрлийг тодорхойлох шинжилгээний аргын стандарт 3. Үйлдвэрлэлд хэрэглэж буй материалд асбестыг илрүүлэх гэрлийг туйлшруулах микроскопын (PLM) шинжилгээний аргын стандарт зэрэг болно. 4. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015” <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн” 2015 оны нэмэлт, өөрчлөлтөөр салбарын төрийн захиргааны төв байгууллага бүрт ХАБЭА-н салбар хороог асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний дэргэд байгуулахаар тусгасан. Салбар хороо нь салбарын хэмжээнд ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг тогтолцоог бий болгосон. 2013 оноос жил МҮЭХ, МАОЭНХ-той хамтран эрсдэл өндөртэй салбарын ажил олгогч, ажилтанд зориулсан сургалтыг бүсчлэн зохион байгуулж хэвшээд байна.</p>
	<p>1.11. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн барилга, уул уурхай, эрчим хүч, зам, тээвэр, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл,</p>	<p>Барилгын салбар дахь ХАБЭА-н чиглэлээр Япон Улсын Засгийн газрын JICA байгууллагатай хамтарсан “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд салбарын хүний нөөцийг чадавхижуулах, сургалтын хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэх, холбогдох хууль эрх</p>

		<p>үйлчилгээний салбарын ажил олгогч, ажилтанд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулдаг болох, үүнтэй холбогдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, зардлын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах;</p>	<p>зүйн орчныг сайжруулах ажил хийгдэж байна. Тухайлбал: “Барилгын ажлын өндрийн аюулгүй ажиллагаа”, “Барилгын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мөчлөг”, “Барилгын ажлын сайн ба муу жишээ” зэрэг гарын авлагуудыг боловсруулсан. Мөн төслийн хүрээнд ХАБЭА-н жишиг танхим, ХАБЭА-н лаборатори байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сургалтын үйл ажиллагааг Барилгын хөгжлийн төв дээр зохион байгуулдаг бөгөөд мөн Барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх төрийн чиг үүргийг шилжүүлэн авсан Монголын барилгачдын холбоо хэрэгжүүлж байгаа.</p>
		<p>1.12. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх зорилгоор Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, эмч, эрүүл ахуйн ажилтныг бэлтгэх, тэдний чадавхийг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;</p>	<p>Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх зорилгоор хөдөлмөрийн нөхцөлийн лабораторийн хэмжээнд 2013 онд 40.000.000 төгрөгөөр 14 нэр төрлийн хэмжилт, шинжилгээний багажтай болов. Мөн ЗЦБ-ийн аппарат, шээсний анализатор, 3D эхогийн аппарат, нүдний биомикроскоп, явуулын флюорограф зэрэг 5 нэр төрлийн багаж тоног төхөөрөмж шинээр хүлээн авч ашиглаж байна.</p>
		<p>1.13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байран дахь сургалт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, осолгүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллагыг нийтэд мэдээлэх;</p>	<p>Үйлдвэрлэлийн орчин нөхцлийг сайжруулж, ажилчдыг ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, санаачлагыг урамшуулан дэмжих, туршлагыг нь дэлгэрүүлэх зорилгоор “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмыг Хөдөлмөрийн сайдын 2013 оны а/61 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах үйл ажиллагаа нь осолгүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллагыг нийтэд мэдээлэх сурталчлах, туршлагыг түгээхэд чиглэдэг.</p> <p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандарт “MNS OHSAS-18001:2012 стандарт”-ын үндэсний зөвлөх бэлтгэх сургалтыг салбараар зохион байгуулж 18 зөвлөх бэлтгэж, 2015 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооог хэрэгжүүлэх заавар OHSAS-18002 олон улсын стандартыг орчуулан үндэсний стандарт болгон батлуулсан.</p> <p>Үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулж, ажилчдыг ажлын байран дахь осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага болзолт уралдааныг 9 дэх жилдээ ХНХЯ, ХАБЭА-н зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, МХЕГ-аас зохион байгуулж байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдыг 2019 оны А/64 дүгээр тушаалаар баталсан шинэчилсэн журмын дагуу “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2019”</p>

			болзолт уралдааны 1-р шатны шалгаруулалтыг аймаг дүүргийн ХАБЭА-н зөвлөл, яамдын ХАБЭА-н салбар хороон дээр 2020 оны 1-2 сард хийж дууссан ба 2-р шатны шалгаруулалтыг ХНХЯ, ХАБЭМТ, МХЕГ-ын хамтарсан ажлын хэсэг гарч зохион байгуулаад байна. Дүнг 5-р сард зарлана.
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017.06.09 №46	<p>1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.</p> <p>“Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	<p>Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлуулж, тус хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ХТҮЗ-ийг арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий Хүүхдийн хөгжил хамгааллын салбар дундын бүлгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал байгуулж, ажилласан.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн 2 дугаар шатны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хамтарсан тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
		<p>1.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах.</p>	<p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй”-н хэсэгт Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ? Хөтөлбөрийг 2019 оны А/494 дүгээр тушаалаар батлуулав.</p>
		<p>1.5. Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах.</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай жил бүр байгуулдаг Үр дүнгийн гэрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаагаанд дэмжлэг үзүүлж, комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тус комисс хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоон шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргаж байна. Энэ хүрээнд орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилал, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамруулж байна.</p>
		<p>1.7. Тусгай сургуульд ажиллаж байгаа багш, ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдлийг</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/228 тоот тушаалаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албаны ажлын байранд мэргэшлийн ур чадвар, ажлын</p>

	<p>шинэчлэн тогтоох, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамааран хувьсах зардлыг нэмэгдүүлэх болон ажилласан жил, ур чадвар, ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулсан багш, ажилтан, албан хаагчдын цалин урамшууллын шинэ тогтолцоог бий болгох, зардлыг холбогдох төсөвт жил бүр тусгах.</p>	<p>хариуцлага, ачаалал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг хүчин зүйлсийг харгалзан үнэлгээ хийх, хүчин зүйлсийн түвшинг боловсруулах, ажлын байрны үнэлгээний аргачлал, удирдамж, асуулга боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.</p> <p>Улмаар 2018 оны 6 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, түүний харъяа Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, 14 аймаг, 8 дүүрэг болон нийслэлийн бүх тусгай хэрэгцээт сургууль цэцэрлэгийн багш ажилтнуудыг хамруулсан ажлын байрны үнэлгээнд нийт 747 байгууллагын 5483 ажилтныг хамруулсан ажлын байрны үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнг үндэслэн Засгийн газрын 2018 оны 263 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх төрийн үйлчилгээний сургалтын байгууллагын албан тушаалын зэрэглэл, мэргэжил олгох боловсролын байгууллагын албан тушаалын зэрэглэлийг тус тус шинэчлэн тогтоож, Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлээр багш, ажилтнуудад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар тооцон олгож байна.</p> <p>Энэхүү шинэчлэлээр багш нарын албан тушаалыг 1-3 зэрэглэл ахиулан цалин хөлс нь 2014 оны түвшнээс 70-75 хувиар нэмэгдсэн байна.</p>
	<p>1.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд болон иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад хамран сургах, сургалтын ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах, сургалтын зардал болон тэтгэлгийг улсын төсвөөс олгох.</p>	<p>Германы GIZ байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТСТМБС) төслийн хүрээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд элсэн суралцах хүртээмжтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.</p> <p>2016-2019 оны хооронд 16 МСҮТ, коллежийн гадаад, дотоод орчинг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгон засварлаад байна. Эдгээр сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч, боловсрол, мэргэжил эзэмших боломж бүрдсэн болно.</p> <p>Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”, суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ 2019 онд Засгийн газрын 12 дугаар тогтоолоор 100.0 мян.төг, 2020 онд 44 дүгээр тогтоолоор 200.0 мян.төгрөг болж шинэчлэгдэн батлагдсан.</p>
	<p>1.14. тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад хүүхдийн тооноос хамааран туслах багш ажиллуулах, цалин, урамшууллыг жил бүрийн төсөвт тусгах.</p>	<p>"Туслах багш" гэсэн албан тушаалыг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар цалингийн сүлжээнд шинээр оруулсан.</p> <p>Одоо ажиллаж байгаа болон шинээр туслах багшаар ажиллах багш нарын цалинг 2020 оны улсын төсөвт тусгуулсан.</p> <p>"Багшийн хөгжлийг дэмжих хууль"-ийн 8.4 дэх хэсэгт "Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно" гэж заасан.</p> <p>Тиймээс ердийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах багшийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.</p> <p>Одоо ажиллаж байгаа тусгай сургууль, цэцэрлэгүүдэд 95 туслах багш ажиллаж байна.</p> <p>Дээд боловсролын байгууллагад туслах багш ажиллуулах шаардлагагүй.</p>

			Сургалтын орчин, сургалтын материал, тоног төхөөрөмжөөр ханган элсэлтийн журамд өөрчлөлт оруулсан ба 2019 оны 6 дугаар сарын байдлаар 6247 хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцаж 8,171.465,479 төгрөг буцалтгүй тусламжаар олгосон.
		2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд, энэ тогтоолын биелэлтийн явцыг 2018 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 1а/5935 тоотоор хүргүүлсэн.
3	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2018.06.21 №56	3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг УИХ-ын 2018 оны 56, Засгийн газрын 2018 оны 250 дугаар тогтоолоор байгуулсан. УИХ, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/233 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрийг батлав.
Нийт 3 тогтоолын 15 заалт			

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	<p>Нийгмийн даатгалын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2012.03.06 №04</p>	<p>1.6/.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагын ажилчдыг нийгмийн даатгалд хамруулах талаар Нийгмийн даатгалын тухай хуульд тодорхой тусгах;</p> <p>1.10/. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хэмжээ, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагчийн тоо нэмэгдэж байгаа боловч нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын орон тоо хасагдсан байна. Иймээс нэг байцаачийн ажлын норм, нормативын хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн тогтоох;</p>	<p>Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгуулага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан журмаар заавал даатгуулахаар зохицуулсан.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлогоос санхүүждэг гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газарт ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” албан журмаар даатгуулахаар тусгасан болно.</p> <p>Мөн хуулийн төсөлд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын байгууллага болон аж ахуйн нэгж нь Монгол Улсын иргэнийг ажиллуулж байгаа бол түүний нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлэхээр заасан.</p> <p>НДЕГ-ын даргын 2012 оны Б/20 тушаалаар аймаг /нийслэл/, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн бүтэц, орон тооны дээд хязгаар, норматив болон байцаагч, ажилтнуудын ажлын үлгэрчилсэн чиг үүргийн шинэчлэн баталсан. Уг тушаалын 6-р хавсралтаар аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн нормативаар ажиллах орон тоо, албан тушаалыг баталсан.</p> <p>Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална” гэж заасны дагуу НДЕГ-ын байцаагч, ажилтнуудын албан тушаалыг НДЕГ-ын дарга, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч, ажилтнуудын албан тушаалыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга тус тус шинэчлэн тогтоосон болно.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд нийгмийн даатгалын байгууллага, байцаагч, ажилтнуудын ачаалалтай уялдуулан ажлын норм, нормативын хэмжээг тогтооходой холбоотойгоор “Аймаг, дүүрэг, сумын нийгмийн даатгалын байцаагчийн орон тооны нормативыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нийт хүн амын тоо, байршил, нягтрал, ажил олгогч, даатгуулагч болон тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоог тус тус үндэслэн санхүү, төсвийн</p>

			болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэсэн заалтыг тусгаад байна.
2	Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх тухай 2014.10.22 №13	<p>1.1/. Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх;</p> <p>1.2/. Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулын үед бэлэн байдлыг хангах сургалтад эрүүл мэнд, хил хамгаалах болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудыг хамруулах, холбогдох байгууллагыг мэдээллээр шуурхай хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>1.3/. Эбола вируст халдварын сэжигтэй өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тусгаарлах эмнэлгийн бэлэн байдлыг хангах;</p> <p>1.4/. Эбола вируст халдвар, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвартай өвчтөнийг тусгаарлах өрөөг хилийн 26 боомтод байгуулах, бэлэн байдлын нөөц</p>	<p>Эбола вируст халдвар гарсан бүс нутагт зорчихгүй байх, урьдчилан сэргийлэх талаар 10 гаруй төрлийн санамж, зурагт хуудас хэвлүүлэн сурталчилж ажилласан. Мөн Эбола вируст халдварын эрсдэлийн үнэлгээг хийж, хамтарсан хариу арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.</p> <p>2014 оны 8 сард Баруун Африкийн зарим улсад голомтлон гарсан Эбола вируст халдвар Монгол Улсын хилээр зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлээс сэргийлэх хүрээнд 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооны хуралдаанаар ЭМЯ-тай хамтран Эбола вирусын халдвараас сэргийлэх чиглэлээр хийж буй ажлын танилцуулгыг хийн, бэлэн байдлыг хангахад шаардлагатай 8.4 тэрбум хөрөнгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргуулах тухай Байнгын хорооны 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 13 тоот тогтоолыг гаргуулсан боловч, санхүүжилт хийгдээгүй.</p> <p>Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулын үед бэлэн байдлыг хангах хүрээнд ДЭМБ-ын санхүүжилтээр ОХУ-ын Буриад Улсын Хүний аюулгүй байдал, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналтын газартай хамтарсан үзүүлэх сургалтыг Алтанбулаг боомтод 2015 онд, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газартай хамтарсан үзүүлэх сургалтыг Замын-Үүд боомтод 2017 онд, ОХУ-ын Буриад Улсын Хүний аюулгүй байдал, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналтын газар болон БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газартай хамтарсан үзүүлэх сургалтыг 2018 онд, Хилийн боомт дахь ХМХА, хэлтсийн улсын байцаагч, ариутгагч нарыг мэргэшүүлэх сургалтыг 2016 онд тус тус зохион байгуулж давхардсан тоогоор нийт хилийн боомт дахь ХМХА, хэлтсийн 200 улсын байцаагч, ариутгагч, ХӨСҮТ, ЗӨСҮТ, Онцгой байдлын байгууллага болон Хил, хяналтын бусад байгууллагын ажилтнуудыг оролцуулж мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Эбола, Зика, Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах хүрээнд өвчлөлийн талаарх мэдээ, зөвлөмж, сэрэмжлүүлгийг ДЭМБ, ЭМЯ-наас өдөр тутам авч Хилийн боомт дахь ХМХА, хэлтсийг мэдээ, мэдээллээр ханган, өдөр тутмын шуурхай удирдлагаар ханган ажиллаж байна.</p> <p>ДЭМБ-тай хамтран Эбола өвчний хариу арга хэмжээний зөвлөмж боловсруулан, ард иргэдийн мэдлэгийг дээшүүлэх, шаардлагатай оношлуураар хангах арга хэмжээ авсан. Мөн ДЭМБ-аас 2 зөвлөх мэргэжилтэнг урьж, Эбола вируст халдварын бэлэн байдалд мэргэжлийн зөвлөгөө авч, хэрэгжүүлэн ажиллалаа.</p> <p>Засгийн газрын хуралдаанд 10 сард хэлэлцүүлж, Засгийн газрын 346 дугаар тогтоол гаргуулан, 477 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслийг авч, эрүүл мэндийн байгууллагуудыг ханган ажиллалаа.</p>

		бүрдүүлэхэд шаардагдах 8.389.320.000 /найман тэрбум гурван зуун наян есөн сая гурван зуун хорин мянга/ төгрөгийн зардлыг /тогтоолын хавсралтаар баталсан/ Засгийн газрын нөөц сангаас гаргах.	
3	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.03.26 №09/03	<p>1.2/. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдралд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган ажиллах, сургалтын хөтөлбөрийг дараагийн шатны сургалтын байгууллагын агуулгад шилжихэд дөхөмтэй байхаар шинэчлэн боловсруулах, мэргэжлийн сургалтад хамрагдаж зохих ур чадвар эзэмшснийг гэрчлэх чадамжийн гэрчилгээ, сертификат, мэргэжлийн үнэмлэх олгох;</p> <p>1.5/. Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах асуудлыг Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, үүрэгжүүлж ажиллуулах;</p> <p>1.14/. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд саадгүй зорчих зам, орц, гарцыг ерөнхий боловсролын</p>	<p>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд нийт 37.806 суралцагч байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 551 суралцагч 44 сургалтын байгууллагад суралцаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдралд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох дагнасан сургалтын 4 байгууллагад нийт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 51.0 хувь нь, үлдсэн 49.0 хувь нь бусад 40 сургалтын байгууллагад суралцаж байна.</p> <p>Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 118 суралцагч 9 мэргэжлээр Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэдэх МСҮТ-дэд 94 суралцагч 7 мэргэжлээр Энэрэл МСҮТ-дэд 60 суралцагч 4 мэргэжлээр Анима Политехник коллежид 7 суралцагч 3 мэргэжлээр суралцаж мэргэжил, ур чадвар эзэмшиж байна.</p> <p>Дээрх сургалтын байгууллагууд тусгай сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор мэргэжил сурталчилах өдөрлөгүүдийг жил бүр зохион байгуулж элсэлт авдаг. Мөн Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургууль 2,5 жилийн мэргэжлийн чадамжийн нэгжийн агуулгыг Политехник коллежийн сургалтын хөтөлбөртэй агуулгыг дүйцүүлэн цаашид дэвшин суралцах хүсэлтэй суралцагчийг техникийн боловсрол олгохоор Монгол-Солонгосын Политехник коллежид дэвшүүлэн суралцуулж байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”, суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ 2019 онд Засгийн газрын 12 дугаар тогтоолоор 100.0 мян.төг, 2020 онд 44 дүгээр тогтоолоор 200.0 мян.төгрөг болж шинэчлэгдэн батлагдсан.</p> <p>Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэмд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээг жил бүр байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тус гэрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаагаанд дэмжлэг үзүүлж ажиллах тухай заалтыг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоотой “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын Ерөнхий шаардлага” MNS6782:2019, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага” MNS6799:2019 зэрэг стандарт батлуулав.</p>

		тусгай сургууль, цэцэрлэгийн орчинд бий болгож, таних тэмдэг байршуулж, гадны автомашин зогсохгүй байхаар журамлах;	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн өгсөн чиглэлийн дагуу ЗТХЯ-ны санаачилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар тусгай сургууль, 186 дугаар тусгай цэцэрлэгийн гаднах орчинг холбогдох стандартын дагуу тохижууллаа. Энэ арга хэмжээнд 100 гаруй сая төгрөгийг бусад яамд, байгууллагуудын хандиваар босгон зарцуулсан болно.
4	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.04.05 №10	1.2/. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээнд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 49 өвчтөний эмчилгээнд хамрагдаж байгаа бол 2019 оны өвчлөлийн прогнозоор олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний тоо 61 болж нэмэгдэх тооцооллоор 48 хувиар нэмэгдүүлж 0,2 тэрбум төгрөг тусгасан. ХДХВ, ДОХ-той өвчтөний гол эмчилгээ болох Ретровирусийн эсрэг эм болон дагалдах халдварын эм, бэлгийн замаар дамжих халдварын эм, дагалдах хэрэгсэлд 0.5 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж 2019 оны төсөвт тусгасан. Нийт 0.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тусгасан. ХДХВ болон БЗДХ-ыг илрүүлэх оношлуурын 70%-ийг улсын төсөв, 30%-ийг Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр ханган хийж байна. ХДХВ/ДОХ-ын эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, тусламж үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийг 100% улсын төсвөөс гаргаж байна. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, сүрьеэгийн диспансер хамтран сүрьеэгийн идэвхтэй илрүүлгийг зохион байгуулж, нийт 15082 хүнийг үзлэгт хамруулж, 59 сүрьеэтэй тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан байна. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээнд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байгаа. 2020 онд улсын төсөвт 3.4 тэрбум төгрөг тусгасан.
		3.2/. Хүн амын эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон зөвлөгөө өгөх төвд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.	"Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр: Тэмбүүг устгая" үйл ажиллагааны хүрээнд УУХҮЯ, ЗТХЯ, ШШГЕГ, ЦЕГ болон Эрдэнэт УҮГ, Эрдэнэс таван толгой УҮГ зэрэг томоохон улсын үйлдвэрийн газар, "Монголын ажил олгогч эздийн холбоо", "Сумын эмч нарын холбоо" ТББ-тай хамтран 19 аймагт уул уурхай, бичил уурхай, алсын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын 9332 ажилтныг үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүү өвчний 136 шинэ тохиолдлыг илрүүлж, эмчилсэн байна.
5	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.12.14	1.9/. Монгол Улсын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, дэн буудал, аялал жуулчлалын болон амралтын газраар үйлчлүүлэгсдийн ерөөнд БЗДХ-аас хамгаалах хэрэгсэл (бэлгэвч) тавьдаг байх талаар холбогдох эрх зүйн актад тусгах.	Монгол Улсын нутаг дэвсгэрт зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд холбогдох стандартын дагуу үйл ажиллагаа явуулах чиглэлээр тогтмол зөвлөмж хүргүүлж, шаардлага тавьж ажиллаж хэвшсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07/7867 дугаар албан тоотой Аялал жуулчлалын хөгжлийн төв болон аймаг, нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хяналт шалгалтыг тогтмолжуулан хамтран ажиллаж хэвшсэн тул хяналтаас хасах саналтай байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/638 тоот тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдан, Дээд зэрэглэлийн зочид буудал болон жуулчны баазад зэрэглэл тогтоох ажлын хүрээнд "Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927: 2008", "Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4934:2002" стандартын дагуу 2-5 одны зэрэглэл, 1-2 цэцгийн зэрэглэл тогтоох ажлыг гүйцэтгэхэд хяналт тавьж хэвшсэн тул хяналтаас хасах саналтай байна.

	№04		
6	Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай 2017.02.16 №17	1.5/. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн үе шаттайгаар нэмэгдүүлж, 2020 он гэхэд ДНБ-ний 2%-д хүргэх, шинжлэх ухааны байгууллагуудын санхүүжилтийг уян хатан, боловсронгуй болгох, бие даан ажиллах, санхүүгийн олон эх үүсвэрийг бий болгох боломж нөхцөлийг бүрдүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 13.1-т "Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын ажлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх" гэсэн арга хэмжээнд улсын төсвөөс 38.4 тэрбум төгрөг төлөвлөн тусгасан нь ДНБ-ий 0.11 хувьд хүрч байна.
7	Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017.02.16 №18	3.3/. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор баталсан.
8	Эрүүл мэндийн бодлого, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2017.05.12 №22	1.2/. "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын 2.2.2-т заасан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх; 1.4/. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх үүднээс эрүүл мэндийн даатгалын бие	Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн санал, Эрүүл мэндийн даатгалын сангийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг Нэгдсэн төсвийн нийт зарлага болон дотоодын нийт бүтээгдэхүүн зэрэгт үндэслэн тооцон боловсруулж урсгал төсвийн саналыг нэмэгдүүлэн жил бүрийн эхний улиралд Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн яам нь ЭМДЕГ-тай хамтран 2019 онд эрүүл мэндийн даатгалын харилцааг зохицуулж байгаа журам, заавар, эрх зүйн баримт бичгийг шинэчлэн сайжруулах, эрх бүхий байгууллагаар батлуулан улсын хэмжээнд нэг мөр мөрдүүлэх, хуулийн хэрэгжээгүй заалтыг

		<p>даасан байгууллагыг байгуулах асуудлыг холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;</p>	<p>хэрэгжүүлэх зорилгоор тогтоол, журмын төслийг боловсруулан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар 17 тогтоол, журам, төсвийн хуваарь батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. ЭМДҮЗ-өөр 2019 онд хэлэлцүүлэн батлагдсан тогтоол, журмын 52.9% нь санхүү, төсвийн чиглэлээр, 41.2% нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр, 5.9% нь бусад асуудал байна.</p> <p>2020 оны 01 дүгээр улирлын байдлаар ЭМДҮЗ-ийн хуралдаанаар нийт 7 тогтоол, журам, төсвийн хуваарь батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулснаар 2018-2019 онд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагч, иргэнд хүргэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах, эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг хуульд заасан чиг үүргийг бие даасан хэлбэрээр хэрэгжүүлж байна.</p> <p>ЭМДҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг баталж, уг бүтцийн дагуу ЭМДЕГ нь 3 газар, 4 хэлтэстэй, 21 аймаг, Багануур, Налайх дүүрэгт эрүүл мэндийн даатгалын тасгийг байгуулсан. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм журам, Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг оновчтой болгох, агентлагийн бүтцийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгоор ЭМДҮЗ-ийн 2019 оны 07 дугаар тогтоолоор ЭМД-ын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан.</p>
		<p>1.5/ Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан багцын тусламж үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн үлдэгдэл хөрөнгийг шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах, сангаас санхүүжиж буй тусламж үйлчилгээний өртөг, зардлыг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ижил зардлаар санхүүжүүлэх нөхцөлийг 2017 онд багтаан судалж, шийдвэрлэх;</p>	<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.16-д “Иргэд-даатгуулагчид хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэхэд эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөх зардлын хэмжээг нэмэгдүүлж, иргэд-даатгуулагчид учирч байгаа эрүүл мэндийн эрсдлээс шалтгаалсан төлбөрийн дарамтыг бууруулах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. 2019 онд ЭМЯ, СЯ, АХБ-ны дэмжлэгтэйгээр хийгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг, өртгийн судалгааны судлаачидтай хамтран судалгааны баг ажилласан. Судалгааны дүнд үндэслэн ЭМДҮЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг 2020 оноос ижил хэмжээтэй буюу 400.000 төгрөг болгон өсгөж, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 33.3 хувиар, хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 128.6 хувь /2.3 дахин/-иар, уламжлалтын тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 113,7%, сувилал болон сэргээн засах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 127,3 хувиар нэмэгдүүлсэн. Энэхүү тарифын өсөлттэй холбогдуулан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний зардлыг 297.7 тэрбум төгрөг буюу 44.4 тэрбум төгрөгөөр өсгөж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд олгох тусламж үйлчилгээний зардлыг 73.2 тэрбум төгрөг буюу 24.4 тэрбум төгрөгөөр өсгөн Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2020 оны төсөвт тусган батлуулсан. 2020 оны 2 дугаар сараас эхлэн ЭМДҮЗ-ийн 28 дугаар тогтоолыг улс орон даяар хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>

	<p>1.6/. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгох, төрөөс төлбөрийг нь хариуцаж байгаа тусламж, үйлчилгээний бодит өртгийг тооцож, тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээгдэхүүнд чиглэсэн худалдан авалтын хэлбэрт шилжүүлэх, эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын худалдан авалтыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулах, ханган нийлүүлэлтийг сайжруулах, тав хүртэлх насны хүүхдийн эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтыг хүүхдийн эмийн хэсгийг тусад нь баталж, 174 нэрийн эмийг 20-80% хөнгөлөлттэй 2018 оноос олгож эхлээд байна. ДЭМБ-аас худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх замаар эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ болон эмийн төсөвт үзүүлэх дарамтыг бууруулах талаар гишүүн орнууддаа зөвлөмж болгодог. Улс орнууд нэгдсэн худалдан авалтыг зохион байгуулах, үнийн хэлэлцээ хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээг ашиглах зэргээр төсвийг үр ашигтай зарцуулах талаар ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн хооронд 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж, зардал хэмнэхээр тусгагдсан. Ерөнхий гэрээ байгуулан эм худалдан авах ажиллагааг анх 2016-2018 онд Азийн хөгжлийн банкны “Улсын эмнэлэгт боломжийн үнэтэй эмийн хангамж хүртээмжийг сайжруулах” техникийн туслалцааны (8967-МОН) төслийн дэмжлэгтэйгээр эхэлсэн. Уг арга хэмжээний хүрээнд 17 нэрийн эмийг 1 жилийн хугацаатай ерөнхий гэрээний дагуу нэгдсэн тендер зохион байгуулж авсан. Мөн Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар Ерөнхий гэрээ байгуулах журам шинэчлэн батлагдсан. Монгол Улсын Засгийн газар ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэн, үйл ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухайд 2019 онд 25 нэрийн эм, 2 нэрийн эмнэлгийн хэрэгслийг, 2020 онд 34 нэрийн эм, 3 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 3 жилийн хугацаатайгаар ерөнхий гэрээ байгуулан авч байна. Ерөнхий гэрээгээр авсан эм, эмнэлгийн хэрэгслийн төсвийг Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нийт төсөвтэй харьцуулахад харьцуулахад 2018 онд 5.1 хувь, 2019 онд 9.1 хувь, 2020 онд 16.2 хувийг эзэлж байна. 2020 оны байдлаар нийт 59 нэрийн эм, 5 нэрийн эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авч байна.</p> <p>Нэр төрлийн хувьд хувьд авч эрүүл мэндийн байгууллагын онцлогоос шалтгаалан 500-900 орчин нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэглэж байна. Дундажаар ерөнхий гэрээгээр авч байгаа эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл 8.4 орчим хувийг эзэлж байгаа боловч орон нутаг бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал Дархан-Уул аймгийн хэмжээнд 2020 оны эм, эмнэлгийн хэрэгслийн нийт төсөв 2,651,359 төгрөг үүний 17.6 хувь буюу 467,380,158 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр авч байна. Нэр төрлийн хувьд авч үзвэл 702 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэглэж байгаагийн 9.1 хувь буюу 58 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр авч байна. Харин Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлгийн тухайд ерөнхий гэрээгээр авах эм нь нэр төрлийн 10.2 хувь, төсвийн 35.3 хувийг эзэлж байгаа бол сумын эрүүл мэндийн төвүүдийн тухайд нэр төрлийн 31 хувь, төсвийн 49 хувийг эзэлж байна. Ерөнхий гэрээгээр эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн тусламжтайгаар цахимаар зохион байгуулагдаж байгаа нь мэдээллийн нэгдсэн сан үүсгэх давуу талтай бөгөөд цахим программын сайжруулалт болон хүний нөөцийн сургалтыг тасралтгүй хийснээр үйл ажиллагаа нь жигдэрч байна. Ерөнхий гэрээний үнийн хоёр дах шатны өрсөлдөөний дүнд 2018 онд 600 гаруй сая төгрөг, 2019 онд 400 гаруй сая төгрөг үнийн өрсөлдөөний үр дүнд хэмнэлт гарсан. Цаашдаа ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.</p>
	<p>1.7/. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах</p>	<p>Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, бэлэн байдлын судалгааг ЭМШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нараар 2018-2019 онд хийлгэсэн. Уг</p>

	<p>зорилгоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, хүний нөөц, санхүүжилтийг боловсронгуй болгох асуудлыг судалж, шийдвэрлэх;</p>	<p>судалгаагаар анхан шатны Улсын хэмжээнд 4 бүсээс 8 аймаг сонгож, аймаг бүрээс нэг нийт 8 ӨЭМТ, 32 СЭМТ, нийслэлийн 9 дүүргээс 30 ӨЭМТ ний 70 эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг хамруулсан. Уг судалгааны хүрээнд анхан шатны тусламж, үйлчилгээнд хэрэгжиж буй хууль эрх зүйн актууд, хүний нөөц, эрүүл мэндийн төвийн байр, эмнэлгийн ор, тоног, төхөөрөмж, үйлчлэх хүрээний хүн ам, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, иргэдийн сэтгэл ханамж зэрэг чиглэлээр хийсэн. Мөн ДБ-ны санхүүжилттэй төслийн хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтэд үнэлгээ хийж, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг үндэслэн Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/257/562 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Ингэснээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт нэмэгдсэн.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг 2017 онд шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжилзүйн газраар MNS 5292_2017-ыг батлуулан, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сум, тосгоны эрүүл мэндийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Тухайлбал: Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлж байсныг өөрчилж, 2018 оноос эхлэн зарим сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ зэрэг 4 төрлийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болсон.</p> <p>2019 онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт, нэг иргэнээр тооцсон тарифыг бодит өртөгтэй уялдуулан шинэчилж, 2020 оноос эхлэн өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон дундаж тарифийг 30000 төгрөг болгосон нь 2015 оноос 2 дахин нэмэгдүүлсэн.</p>
	<p>1.8/. Эрүүл мэндийн болон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, цалин, урамшуулал, тэтгэмжийн сүлжээг боловсронгуй болгох асуудлыг эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран шийдвэрлэх, шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгах;</p>	<p>Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчилж, цалин хөлсний оновчтой тогтолцоо бий болгох зорилгоор ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоог бүрдүүлэх аргачлалыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/107-А/230 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлсэн.</p> <p>Төв, орон нутгийн эрүүл мэндийн шатлалын 30 байгууллагын 2600 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнээс ажлын байрны үнэлгээ хийх асуулга авч, дүнг нэгтгэн боловсруулав. Ажлын байрны үнэлгээний үр дүн болон ажлын байрны ангилал, зэрэглэлийн төслийг “Ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх нь” сэдэвт ОУХБ, нийгмийн түншлэгч талууд, салбарын яамдын төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлэгт танилцуулав.</p> <p>Эрүүл мэндийн болон боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор</p>

			<p>эмнэлгийн мэргэжилтний албан тушаалын зэрэглэлийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөлжсөн нарийн мэргэшлээр албан тушаалын 1-3 зэрэглэл ахиулан тогтоосон. Энэхүү шинэчлэлээр, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол, 2019 оны 24 дүгээр тогтоол, 2019 оны 472 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг тус тус 8.0 хувиар нэмэгдүүлэх, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор 2020 оноос эхлэн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар тооцож цалин хөлсийг олгож эхэлснээр салбарын ажиллагчдын цалин 70.0-иад хувиар нэмэгдээд байна.</p>
		<p>1.9/. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амд жигд, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага, сахилга бат, ёс зүй, хандлагыг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Эрүүл мэндийн яамнаас 2019 оныг “Инээмсэглэл-Эерэг хандлага”-ын жил болгон зарлаж, энэхүү аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын А/179 дүгээр тушаалаар батлуулан ажилласан. Тухайлбал:</p> <p>“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт сургалтыг Орхон, Булган аймагт зохион байгуулж, ЭМГ, ЭМБ-уудын удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн нийт 120 хүн оролцсон. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, эрүүл мэндийн байгууллагын ёсзүйн салбар хороодын үйл ажиллагаанд хурдавчилсан үнэлгээ хийх ажлын удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулж, Архангай, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, 11 сум, 5 өрхийн эрүүл мэндийн төвд тусгайлсан асуумжаар үнэлгээ хийв. Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага ёс зүйг сайжруулах, ёс зүйн алдаанаас сэргийлэх, эмнэлгийн мэргэжилтний бахархал, эрүүл мэндийн салбарын нэр хүндийг өргөх, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 406 дугаар тушаалаар батлуулсан. Эмнэлгийн мэргэжилтний баримтлах зарчим, Эмнэлгийн мэргэжилтэн-Үйлчлүүлэгчтэй харилцах, Эмнэлгийн мэргэжилтэн хоорондоо харилцах, нийгэм, хэвлэлтэй харилцах, эмнэлгийн мэргэжилтэн өөрийгөө таних, Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтаны ёс зүй, харилцааны хэм хэмжээг нэгдүгээр хавсралтаар, хоёрдугаар хавсралтаар Эрүүл мэндийн байгууллагаар Үйлчлүүлэгчийн ёс зүйн эрх, үүргийг тусган батлуулсан. Эрүүл мэндийн байгууллагын бүх шатны тасаг нэгж Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн сургалт зохион байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/19 дүгээр тушаал батлуулж, эмнэлгүүд сургалтаа сар бүр зохион байгуулж, улирал бүр тайлан ирүүлж байна. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн бүх шатны Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны дарга, гишүүдэд “Сайн туршлагаасаа харилцан суралцах арга зүйн сургалт”-ыг Дэлхийн банктай хамтран 2019 оны 5 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтанд ёс зүйн хорооны 73 гишүүд оролцож, туршлагаа хуваалцсан. 21 аймаг, эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх ёс зүйн салбар хороодын ажлыг шалгаруулах ажлыг зохион байгуулав. 18 аймгийн эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороод, Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг сумдын ёс зүйн салбар хороо, нэгдсэн эмнэлгийн ёс зүйн хэсгийн хороо, багийн үйл ажиллагаатай танилцаж, ёс зүйн хороодын үйл ажиллагааг арга зүйгээр хангаж ажиллан гишүүдэд зөвлөгөө өгч, арга зүйгээр хангаж ажилласан. Эмнэлгийн мэргэжилтний мэндчилгээ, угтах, үдэх, сонсох ур чадвар, ажлын байран дахь хувцаслалт, эерэг харилцаа гэсэн харилцааны сэдвүүдээр Япон улсын Жайка-н төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн багтай хамтран онол, дадлага хосолсон сургалтыг нийт 11 удаа зохион байгуулж, сургалтанд 372</p>

		<p>мэргэжилтэн хамрагдаж, нэг багц цагийн гэрчилгээ олгогдсон. Харилцаа, хандлага, ёс зүйн 6 модулийн хөтөлбөр батлуулж, ёс зүйн 2 багц цагийн сургалтыг ёс зүйн хяналтын хорооны гишүүд 19 аймаг, зарим сумын эрүүл мэндийн төв, дүүргийн эмнэлэг, улсын төв эмнэлгүүдэд зохион байгуулж, сургалтанд 7450 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан.</p>
	<p>1.10/. Эмийн аюулгүй байдлын мэдээллийн цахим тогтолцоог үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;</p>	<p>Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, ЗШЭ-ийн жагсаалтад орсон ЭМДС-аас хөнгөлөлттэй олгох эмэнд өрхийн эмч нар 100% цахим жор бичсэн байна. Эмийн цахим жорын програмыг Лайсмед мэдээний цахим програмтай уялдуулан, ЭМДС-аас хөнгөлөлттэй олгох эмийг цахим жороор олгож байна.</p> <p>Нийт 612 эрүүл мэндийн байгууллагын 2633 эмч, 1058 эмийн сан цахим жорын программд холбогдсон.</p> <p>2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ЭМДС-аас хөнгөлөлттэй олгох 2083014 эмийн жор бичсэн ба үүнээс үйлчлүүлсэн иргэдийн тоо-582162 байна.</p> <p>Дээрх суурилуулсан эмнэлэг, эмийн сангуудад уг программын талаарх сургалт мэдээлэл ажлын байранд болон цахимаар явуулах үйл ажиллагаа тогтмолжсон.</p> <ul style="list-style-type: none"> - Лайсмэд эмийн цахим программд 4077 импортын эмийн бар кодыг оруулаад байна. - Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, эмийн үйлдвэр болон Эм ханган нийлүүлэх байгууллагууд уг программд холбогдон цахимаар импортын лицензийн зөвшөөрлийг авч байна. - Эмийн гаж нөлөөний бүртгэл мэдээлэх үйл ажиллагааг цахимжуулахаар уг программд суулгаж эхэлсэн. <p>2020 оны 1 улирлын байдлаар: Цахим жорын програмд холбогдсон өрхийн эрүүл мэндийн төв-519, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэг -75, Цахим жор бичсэн эмч-2243 Цахим жороор үйлчилсэн эмийн сан-1059 Цахим жороор үйлчлүүлсэн иргэд-268143</p>
	<p>1.12/. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн цагийг сургалтын хөтөлбөрт сэргээн оруулах, шаардлагатай мэргэжлийн багшийг бэлтгэх;</p>	<p>"Эрүүл мэнд" боловсрол олгох хичээлийн агуулга, хөтөлбөрийг Хувийн эрүүл ахуй-орчны эрүүл мэнд, Хооллолт-хөдөлгөөн, Сэтгэцийн эрүүл мэнд, Хорт зуршил, Бэлгийн болон НҮЭМ, Жендэр, хүчирхийлэл, Аюулгүй байдал-анхны тусламж гэсэн 6 чиглэлээр боловсрогдож, багш нар бэлтгэгдэн 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн БСШУС-ын сайдын 2018 оны А/453 дугаар тушаалын дагуу орж байна.</p>
	<p>1.13/. Эрүүл мэнд, анагаах ухааны боловсрол олгодог их, дээд сургуулийн харьяа сургалтын бааз эмнэлэг байгуулах, дээрх сургуулийн харьяаллыг өөрчлөх эсэхийг судлах, элсэгчдийн хяналтын тоог эрүүл мэндийн салбарын бодлоготой уялдуулан тогтоох, шинэ сургууль, анги нээх,</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг байгуулах тухай" 53 дугаар тогтоолоор Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэгт эрүүл мэндийн салбарын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/389 дүгээр тушаалаар байгуулж, шаардагдах хүний нөөц, дэд бүтцийн бэлэн байдлыг хангаж, шаардагдах санхүүжилтын тооцоо, судалгаа, төсвийг батлуулж, ЭМЯ-аас Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай</p>

		<p>магадлан итгэмжлэх асуудлыг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран судалж, шийдвэрлэх.</p>	<p>зөвшөөрлийг 2019.10.01-ний өдөр олгож, иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа мөн өдрөөс эхэлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 125 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харъяанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв” байгуулагдаж, дүрмийг баталсан. Тус тогтоолын 2.2-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх, хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл үйлдвэрлэх, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгон, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.</p>
9	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25</p>	<p>1.3/. хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийг барих санаачлагыг дэмжиж, урт хугацаатай бага хугацаатай зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх;</p>	<p>Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталж 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9-д Боловсролын тухай хуулийн 12.1-д заасан боловсролын байгууллагын үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлж байна.</p>
10	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №26</p>	<p>1.а6/. суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Засгийн газар баталдаг болох;</p>	<p>Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний 70 дугаар тогтоолоор “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын 3 дахь хэсэгт Сургалтын төлбөрийн зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зохицуулна.” гэж нэмж тусгасан. Журмын төслийг 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.</p>
		<p>1.а7/. дэвшилтэт технологийг бүтээх, дамжуулах, зүгшрүүлэх, нутагшуулах, үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрүүлэхэд зээл, татварын таатай эрх зүйн орчин бүрдүүлэх;</p>	<p>Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталж 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.4-д зааснаар улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлж байна.</p>
		<p>1.б.3/. үр дүн, үнэ цэнэ нь тодорхой, хэрэглээ, үйлдвэрлэл, эдийн засагт нэвтрэх баталгаа нь хангагдсан ноу хау, бизнес-инноваци, технологийн ажлуудад судалгааны тэтгэлэг олгодог санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгох, хөгжүүлэх;</p>	<p>Докторын зэрэгтэй залуу судлаачдын бие даан эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж, үр дүнд инноваци бий болгоход чиглэсэн докторын дараах судалгааны гүйцэтгэгчид “Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг” олгох хөрөнгийн эх үүсвэрийг ШУТС-ийн тусгасан.</p>
		<p>2. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг Боловсрол,</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн Зорилт 13. “Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ.” гэсний дагуу 4 бодлогын арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.</p>

		соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.	
11	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.22 №14	<p>1.а.1/. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах;</p> <p>1.а.2/. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байгаа жижиг зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй олгох механизмийг бий болгох;</p> <p>1.а.4/. ажлын байрыг тогтвортой хадгалан, ажилтнаа ажилгүй болохоос сэргийлж байгаа ажил олгогчийг дэмжих, энэ чиглэлийн бусад шинэ туршлагыг нэвтрүүлэх, ажилтны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах болон зээлийг үр ашигтай зарцуулах талаарх сургалтыг идэвхжүүлэх, чадавхжуулах;</p> <p>1.б.1/. Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд: нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн нэр төрлийг оновчтой тогтоож, багцлах, халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинд хүргэж нэмэгдүүлэх;</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд Улсын төсвөөс 2019 онд 28,5 тэрбум төгрөг хуваарилсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд олгож байгаа зарим санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд дээрх хуулийн 22.1.2-т заасны дагуу орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилан, санхүүжүүлж ажилладаг. Тухайлбал, 2018 онд Өмнөговь аймаг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 200,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2019 онд Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөс санхүүжүүлэхээр 8.0 тэрбум төгрөг батлан 2019 оны 12 сард 107 иргэнд 1,5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2020 онд 18.0 тэрбум төгрөгийг баталж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан 21 аймагт зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэж Хаан болон Төрийн банкуудаар дамжуулан жижиг зээлийг олгож эхлээд байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ажил олгогчийг дэмжих арга хэмжээгээр тогтвор сууршилтай ажиллуулж байгаа ажил олгогчийг дэмжиж урамшуулал олгодог. 2019 онд энэ арга хэмжээгээр нийт 202 иргэн, 140 ажил олгогч хамрагдаж 669,8 сая төгрөгийн дэмжлэгийг авсан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 726 иргэн хамрагдаж 110 ажил олгогч хамрагдаж 1,044,3 сая төгрөгийн дэмжлэг олгосон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах болон зээлийг үр ашигтай зарцуулахад зээлийн өмнөх сургалтаар чадавхижуулж зээлд хамрагдуулдаг.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өнгөрсөн хугацаанд тухайн жилд тэтгэвэр нэмэгдүүлэхээр батлагдсан төсөвт багтаан нэмэгдүүлж ирсэн учраас амьжиргааны түвшний хамгийн доод хэмжээнд хүрэхээр хангалттай байдаггүй байсан. Иймд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2019 оноос амьжиргааны доод түвшинд хүргэж нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2020 оны 25 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2019 оны хүн амын амьжиргааны түвшний зүүн болон төвийн бүсийн хэмжээнд хүргэж нэмэгдүүлж, 188.0 мянган төгрөг болголоо. Энэ нь нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан хагас, бүтэн өнчин хүүхдүүд, 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхэд зэрэг нийгмийн халамж шаардлагатай иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд томоохон дэмжлэг болсон юм.</p>

	<p>1.б.2/. ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын цалингийн шатлал, зэрэглэлийг шинэчлэх;</p>	<p>Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлд төрөлжсөн асрамж, халамж, сэргээн засах эмнэлгийн ажилтан, албан хаагчдын албан тушаалыг эмнэлгийн мэргэжилтний албан тушаалын зэрэглэлтэй дүйцүүлж, албан тушаалын 1-3 зэрэглэл ахиулан тогтоосон.</p>
	<p>1.б.3/. Ахмад настны үндэсний төвийн дэргэдэх ахмадын нөхөн сэргээх сувиллыг үндсэн чиглэлээр ажиллуулах;</p>	<p>Ахмад настны үндэсний төвийн дэргэдэх Нөхөн сэргээх сувилал нь Төв аймгийн Эрүүл мэндийн газраас сувиллын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсны үндсэн дээр Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д заасан ахмад настанд сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтад орж 2018, 2019 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллаж байна. 2019 онд нийт 2602 ахмад настанд сэргээн засах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна.</p>
	<p>1.б.5/. хүүхдийн асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ Нийтлэг шаардлага, MNS 6517:2017 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар батлуулж, стандартыг хэрэгжүүлж ажиллах талаар 31 халамж асрамжийн төвийн удирдлага нийгмийн ажилтан 58 хүнд арга зүйн сургалт зохион байгуулсан. 2018 оноос төвлөрсөн асрамжаас хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжих ажлыг туршин хэрэгжүүлж байна. Стандартын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээг МХЕГ, ЦЕГ, ОБЕГ-тай хамтран жил бүр зохион байгуулж хэвшсэн.</p>
	<p>1.б.6/. асрамж, халамжийн төвүүдэд амьдарч буй хүүхдүүдийг амьдрах ухаанд сургах, төвүүдээс насанд хүрээд гарч буй залуучуудын амьдралыг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэх.</p>	<p>Хүүхэд: Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилтийн дагуу 10-15 настай хүүхдэд зориулсан “Миний найз” хөгжлийн хөтөлбөрийг 2015-2017 онд туршилтаар хэрэгжүүлж, давхардсан тоогоор 500 орчим хүүхдийг хамруулсан. Тус хөтөлбөрийн Миний харилцаа, Миний эрүүл мэнд, Миний эдийн засаг, Миний оролцоо, Миний орчин 5 дэд бүлгийн хүрээнд хүүхдүүд амьдрах ур чадварт суралцсан. Залуучууд: Насанд хүрч, асрамж, халамжийн төвөөс гарч буй залуучуудын хөгжил, хамгааллыг дэмжих, нийгмийн амьдралд хөл нийлүүлэн амьдрах чадварыг сайжруулах “Асрамж халамжийн төвийн залуучуудын бие даан амьдрах чадварыг хөгжүүлэх жишиг хөтөлбөр”-ийг туршилтаар хэрэгжүүлж байна. Жишиг хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, өсвөр үе, залуучуудын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хүүхэд бүрт хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, санхүүгийн боловсрол олгох, мэргэжлийн клуб дугуйлан, богино/урт хугацааны сургалтанд хамруулах, харилцааны ур чадвар олгох, эрүүл мэндийг дэмжих, урлаг, спортоор дамжуулан эх оронч сэтгэлгээтэй, сайн иргэн болгон төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байранд дадлагажуулах зэрэг чиглэлээр менторинг багшийн тусламжтайгаар бие даан амьдрах чадвар, чадамжийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Цаашид тус хөтөлбөрийн орон нутаг дахь хэрэгжилт, зохион байгуулалтыг аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүд хариуцан хэрэгжүүлнэ.</p>

		<p>2. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.</p>	<p>Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинд хүргэж нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг 2019, 2020, 2021 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2019 онд 21.2 тэрбум, 2020 онд 17.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгав. 2021 оны улсын төсөвт 17,6 тэрбум төгрөгийг төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан.</p>
12	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Засгийн газарт чиглэл өгсөн хуралдааны тэмдэглэл 2018.05.22</p>	<p>1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журмыг үндэсний зөвлөлийн бүх гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэж, холбогдох хуулиудад нийцүүлэн өөрчлөлт оруулж батлах;</p> <p>2. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сан тус бүрийн сарын зарлагыг нарийвчлан тооцох, арилжааны банкинд байршуулахдаа харилцах, хадгаламжийн зохистой харьцааг хангах, банкуудын хадгаламжийн дундаж хүүг баримтлан нэн даруй байршуулах, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрт шилжүүлэх;</p>	<p>Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг баталсан.</p> <p>Шинэчлэн боловсруулсан дүрэмд “Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зарчим”, “Үндэсний зөвлөлийн хуралдаан”, “Үндэсний зөвлөлийн ажлын алба”, “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх” гэх мэт бүлгүүдийг шинээр оруулсан.</p> <p>Мөн дүрмийн бусад 13 зүйлийг шинэчлэн найруулж, 2 зүйлийг шинээр нэмж оруулсны дээр 10 зүйлийн бүлгийг өөрчилж, холбогдох бүлэгт нь оруулах найруулгын өөрчлөлт хийгдсэн.</p> <p>УИХ-ын Байнгын хорооноос баталсан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн 5.5 дахь заалтад "Үндэсний зөвлөл"-ийн хурлыг 6 ба түүнээс дээш тооны саналын эрхтэй гишүүдийн ирцтэйгээр хуралдуулна" гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хэлэлцэж баталж байгаа асуудлуудыг Үндэсний зөвлөлийн гишүүдийн 6 дээш гишүүний оролцоотой хуралдан, хэлэлцэж байна.</p> <p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”, “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-ний загварыг шинэчлэн батласан.</p> <p>Шинэчлэн боловсруулсан журмыг хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын сангийн мөнгөн хадгаламж байршуулахад баримтлах зарчим, арилжааны банкуудад тавигдах шалгуур үзүүлэлтүүд тодорхой болж, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад эрсдэлгүй хадгалуулж, өсгөн нэмэгдүүлэх нөхцөл бүрдэж байна.</p> <p>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хүүгийн доод хэмжээг тухайн үеийн Монголбанкны бодлогын хүү, банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээтэй уялдуулан Засгийн газрын бондын хүү, Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү болон арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс доошгүй байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтоож байна. Монголбанкны бодлогын хүүгийн хэмжээ 2018 оны 3 дугаар сард 10 хувь, 11 дүгээр сард 11 хувь болж хоёр удаа өөрчлөгдөхөд нийгмийн даатгалын сангийн мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг Монголбанкны бодлогын хүү, Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, арилжааны банк хоорондын захын хүү, банкуудын нийтэд зарласан байгууллагын хугацаатай хадгаламжийн хүү болон Монголбанкны саналыг үндэслэн 2018 оны 8 дугаар сард 13 хувиар, мөн оны 12 сард 14 хувиас багагүй байхаар тус тус шинэчлэн тогтоосон.</p>

		<p>ЭМДҮЗ-ийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банканд хадгалуулах журам", 2019.07.29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор "Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалуулах, ЗГ-ын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах журам"-ыг шинэчлэн баталсан. /Үүнтэй холбоотойгоор 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болгосон./ "Хөрөнгийн зохистой харьцаа тогтоох тухай" ЭМДҮЗ-ийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоол батлагдсан. Үүнд:</p> <p>1.ЭМДС-ийн харилцах дансанд байвал зохих хөрөнгийн хэмжээг тухайн жилийн батлагдсан төсвийн гурван сарын зарлагын дүнгээр, Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг ЭМДҮЗ-ийн тухайн жилийн баталсан хэмжээгээр тус тус тооцож харилцах дансанд байршуулсугай.</p> <p>2. ЭМДС-ийн харилцах дансанд байвал зохих хөрөнгө болон эрсдлийн сангийн хөрөнгөөс бусад үлдэгдэл хөрөнгийг Засгийн газрын бонд болон арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсугай.</p> <p>Мөн 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор ЭМД-ын эрсдэлийн санг "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулах"-аар, 2019 оны 10 дугаар сарын 03-ны 21 дүгээр тогтоолоор ЭМДСангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн 1 жилийн хүүгийн хэмжээг 14 хувиас багагүй байхаар тогтоон, шинээр мөнгөн хадгаламж байршуулах, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 29 дүгээр тогтоолд ЭМДС-ийн чөлөөт үлдэгдэл 189.9 тэрбум төгрөгөөр Монгол банкны үнэт цаас худалдан авахыг зөвшөөрсүгэй гэж тус тус заасныг үндэслэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	<p>3. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдах, хүүгийн орлогыг нэмэгдүүлэх, хадгаламжид байршуулалгүй харилцахад байршуулж байгаагаас учирсан хохирлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;</p>	<p>Нийгмийн даатгалын санд 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 694.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байснаас хадгаламжид 335.3 тэрбум төгрөг, харилцах дансанд 358.8 тэрбум төгрөг байсан.</p> <p>Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны "...харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрт шилжүүлэх" чиглэлийн дагуу Капитал банкны харилцах дансанд байршиж буй хөрөнгөөс 79.0 тэрбум төгрөгийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 9 сарын хугацаанд нэг жилийн 15.2 хувийн хүүтэйгээр хадгалуулахаар шилжүүлэн байршуулсан.</p> <p>Энэ арга хэмжээ нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.</p>
	<p>5. Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг байршуулахдаа арилжааны банкуудын чөлөөт өрсөлдөөний зарчмыг хангаж ажиллах, холбогдох гэрээг Монголбанкны</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулахдаа чөлөөт өрсөлдөөний зарчмыг ханган банкуудад мэдээллийг тэгш хүргэн хадгалах мөнгөн дүн, хүүгийн хэмжээний саналуудыг авч байна.</p> <p>"Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам"-д заасны дагуу хадгаламж байршиж буй банкуудаас сар бүр санхүүгийн болон Монголбанкны санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй тайланг хүлээн авч, хяналт тавин ажиллаж байна. Монголбанкны мөнгөний бодлогын хүү, банкуудын нийтэд зарласан нэг жилийн хугацаатай байгууллагын хадгаламжийн хүүг сар бүр авч, судалгаа хийн ажиллаж байгаа болно.</p>

		бодлогын хүүтэй уялдуулан улирал тутамд шинэчилж байх;	Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болгон авсан хүүгийн аль өндөр хэмжээнээс буулгахгүй байх гэснээр мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг 11.8 хувь байлгав. Хадгаламж байршуулах 2020 оны №А-1/37 тоот албан бичгээр банкны системд нөлөө бүхий банкнуудаас мөнгөн хадгаламж байршуулах саналыг авч нэгтгэн ЭМДҮЗ-ийн хурлаар танилцуулав.
		6. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн мэдээллийг улирал бүр тус Байнгын хороонд ирүүлж байх;	Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн мэдээлэл, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр гаргуулан Байнгын хороонд хүргүүлэн ажиллаж байна. ЭМДҮЗ-ийн ажлын албанаас Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийн мэдээллийг улирал бүр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд албан бичгээр хүргүүлж байна. Тухайлбал 2019 оны 12 дугаар сарын эцсийн байдлаарх мэдээг 2020 оны 1 дүгээр сарын 14-ний 09 тоот, 2020 оны 1 дүгээр улирлын мэдээг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны 48 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.
		7. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл жилийн ажлынхаа тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.8-д заасан хугацаанд ирүүлж, цаашид хуулийн хугацаа хэтрүүлэхгүй байх.	2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 59 дүгээр албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн жилийн ажлын тайланг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргад хүргүүлэн Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос өгсөн чиглэлийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралд танилцуулж, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын албанд жилийн ажлын тайланг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэн хүргүүлээ. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний зөвлөлийн гишүүдэд танилцуулан, саналыг тусгаж, Монгол улсын УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан хугацаанд буюу 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 44 тоот албан бичгээр Нийгмийн Бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны байнгын хороонд хүргүүлсэн.
13	Агаарын бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай /БОХХААБХ/ НБСШУБХ/ 2018.05.30 №07/16	1.1/. тогтоолын заалтуудыг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзэн, хөрөнгийн эх үүсвэр, хүрэх үр дүнг заасан нэгдсэн төлөвлөгөөг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор баталж, хэрэгжүүлэх;	Тогтоолын хэрэгжилтийг хангахаар 2017.03.20-ны өдрийн ҮАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Ерөнхий сайдын 51 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо болж шинэчлэгдэн зохион байгуулагдсан бөгөөд 2019 онд БОАЖ-ын сайдын 2019 оны А/222, А/734 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны орон тоо, бүтцийг шинэчлэн зохион байгуулж байнгын ажиллагаатай бүтцийг бий болгосон. Тус хорооны тогтоолоор жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийг батлан хэрэгжүүлж үйл ажиллагаа тогтмолжсон.
		1.2/. тогтоолын 1.2, 1.3, 1.7 дугаар заалтын хэрэгжилт хангалтгүй байх тул холбогдох шийдвэрийг гаргаж, 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн хуулийн хугацаанд танилцуулж шийдвэрлэсэн.
		1.3/. агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил, арга хэмжээг нэгдсэн байдлаар уялдааг	2017.03.20 ҮАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Ерөнхий сайдын 51 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо болж шинэчлэгдэн зохион байгуулагдсан бөгөөд 2019 онд БОАЖ-ын сайдын 2019 оны А/222, А/734 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны орон тоо,

	ханган шийдвэрлэж, ажлыг эрчимжүүлэх;	бүтцийг шинэчлэн зохион байгуулж байнгын ажиллагаатай бүтцийг бий болгосон. Мөн үндэсний хорооны дэргэд Зөвлөлдөх эрдэмтдийн баг ажиллуулах ажлын удирдамж батлагдсан. Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтэд 4600 сайн дурын орон тооны бус ажилчид, Нийслэлийн мэргэжлийн хяналтын Агаарын чанарын хяналтын хэлтэст явуулын 4 пост байгуулж, 24 гэрээт ажилтан, Цагдаагийн Ерөнхий газарт “Эргүүл хяналт шалгалтын нэгж” байгуулагдаж, 58 албан хаагчидтай бие бүрэлдэхүүн, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 128 хүний бүрэлдхүүнтэй хяналт, шалгалтын баг тус бүр түүхий нүүрсний хяналт, галлагаа, аюулгүй байдал, үнс зэрэгт хяналт тавин мэдээлэл түгээж байгаа ба энэ ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран ажиллаж хэвшсэн.
	1.4/. агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2018, 2019 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож, нэн даруй хэрэгжүүлэх;	2019 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 75.2 тэрбум төгрөгийг хуулийн дагуу нийт 32 арга хэмжээнд зарцуулсан бол 2020 онд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 53.0 тэрбум төгрөг зарцуулан сайжруулсан түлш үйлдвэрлэх хүчин чадлыг 600.0 мянган тонноор нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүчний хэрэглээг дэмжих, нийтийн тээврийн агаарт ялгарах бохирдлыг багасгах, аймгуудын агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, аймгуудын дулааны эх үүсвэрт утаа шүүх шүүлтүүр тавих зэрэг арга хэмжээг; хөрс, усны бохирдлыг бууруулах арга хэмжээнд 8.0 тэрбум төгрөг зарцуулан гэр хорооллын нүхэн жорлонг өөрчлөн сайжруулах, төв цэвэрлэх байгууламжаас гарах бохирдлыг бууруулах; хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд 10.0 тэрбум төгрөг зарцуулан хог хаягдлыг дахин боловсруулах болон аймаг орон нутгийн хог хаягдлыг бууруулах; агаар, орчны бохирдлыг бууруулах инноваци, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, мониторингийн сүлжээг сайжруулах, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч үр дүнтэй ажиллаж байна.
	1.5/. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хандсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой санал, санаачлага, төсөл, арга хэмжээг судлан үзэж, үр ашигтай төсөл, арга хэмжээг салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор сонгож, улс, орон нутгийн төсөв, хөнгөлөлттэй зээлийн хэмжээнд багтаан саналыг нэгтгэх;	2019 онд жилд 600 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлвэрлэх, гэр хорооллын айл өрхүүдийг угаарын хий /CO/-н хордолтоос сэргийлэх мэдрэгчээр хангах, улсын төсөвт 36 байгууллагын халаалтыг цахилгаан, байгалийн хий, газрын гүний дулааны халаалтад шилжүүлэх, 101 кВт-аас дээш хүчин чадалтай 220 усан халаалтын зуухны янданд усан шүүлтүүр суурилуулах, байгалийн шатдаг хийгээр ажилладаг 70 автобус нийлүүлэх, 24 дизель хөдөлгүүртэй автобусны хөө тортгийг 90% бууруулах шүүлтүүр тавих, том оврын 400 автобусанд бохирдлыг бууруулах төхөөрөмж суурилах, гэр хорооллын иргэдэд цахилгаан халаагуур, байшин, сууцны дулаалга, эко жорлонгоо шийдэхэд нь дэмжлэг болох зорилгоор иргэдэд жилийн 9 хүртэл хувийн хүүтэй 40 хүртэл сая төгрөгийн ногоон зээлийг Төрийн банк, Хаан банк, Хас банкнуудтай хамтран олгох, зээлийн хүүгийн татаасанд дэмжлэг үзүүлэх, 4 төрлийн агаар цэвэршүүлэгч, 10 төрлийн эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ыг урамшуулж ногоон гэрчилгээ олгох, "Агаар, орчны бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", "Гэр байшингаа дулаалъя, сайжруулсан шахмал түлш хэрэглэе, ногоон зээлд хамрагдаж агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", "Одонтой ээжүүд агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэж байна", "Хандлагаа өөрчлөө", "Хоггүй цэвэрхэн Монгол" зэрэг уриалгуудыг олон нийтэд хүргэх зэрэг ажлуудыг хөтөлбөрийн 1-р үе шатанд амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 2019 онд Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 19-38%-иар, PM10 тоосонцор 3-43%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

		<p>1.6/. тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа асуудалд дүгнэлт хийж, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, тогтоол, ажлын хэсгийн зөвлөмжүүдийн хүрээнд хийгдэж буй ажлын тайланг сар бүрийн эхний долоо хоногт танилцуулж байх.</p>	<p>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хэвшсэн.</p>
		<p>3. Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар 2018 оны 10 дугаар сарын 05-ны дотор Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.</p>	<p>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, асуудлыг Ерөнхий сайдад болон холбогдох Байнгын хороодод танилцуулж хэвшсэн.</p>
<p>14</p>	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17</p>	<p>1.3/. мэргэжлийн боловсрол, сургалтын багш бэлтгэх, давтан сургах төв ажиллуулах;</p> <p>1.5/. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын</p>	<p>Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багшийг тасралтгүй хөгжүүлэх механизм, чиг үүргийг бий болгохдоо салбарын бүтцийн байгууллагуудтай давхардуулахгүй оновчтой нэгдсэн механизм, бүтцийг бий болгон өөрчилсөн. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 216 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийг байгуулсан ч 2016 оны Монгол Улсын Засгийн газрын 55 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болгон өөрчлөн зохион байгуулсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын даргын 2011 оны 137 дугаар тушаалаар Улаанбаатар, Баруун, Зүүн, Говь, Хангай, Төвийн 6 бүсийн арга зүйн төв байгуулсан. Гэсэн ч Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон Бүсийн арга зүйн төв гэсэн 2 байгууллагын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль” -аар олгосон чиг үүргүүд 70-80 хувь нь давхардалтай байсан.</p> <p>Иймд Монгол улсын Засгийн газрын 2019 оны 366 дугаар тогтоолоор МБС-ын Үнэлгээний төв, МБС-ын Бүсийн арга зүйн төвүүдийн үйл ажиллагааны давхардлыг арилгаж, нэгтгэн зохион байгуулах замаар багшийн хөгжил, судалгаа, инновацийн шинэ чиг үүргийг гүйцэтгэх “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв” болгон өөрчлөн зохион байгуулсан. Тус төв нь багшийн хөгжил, судалгаа, арга зүйн алба, мэдээллийн технологи, үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн алба, бүс хариуцсан арга зүйн алба гэсэн 3 алба, 9 нэгж, 49 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Багшийн хөгжил арга зүйн алба нь МБС-ын салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж мэргэшүүлэх, чадавхжуулах, багш бэлтгэх, давтан сургах, багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургалтын арга зүйгээр ханган ажиллаж байна.</p> <p>“Хоолны зардлын норматив тогтоох тухай” Засгийн газрын 2020 оны 83 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг</p>

		<p>мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив болон дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх;</p> <p>1.7/. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн зохицуулалтыг тодорхой болгох, "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих" журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж шийдвэрлэх;</p> <p>1.8/. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлгийн тооцоо, судалгааг хийн шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах;</p> <p>1.10/. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг сурах бичгээр хангах, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах.</p>	<p>сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны зардал 2315 байсныг 3000 төгрөгөөр шинэчлэн тогтоосон.</p> <p>Мөн Засгийн газрын 2019 оны 388 дугаар тогтоолоор "Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив"-ыг шинэчлэн баталж, 2021 оны төсөвт талаар чиглэлийг гаргаад байна.</p> <p>"Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэсэн заасны дагуу тус журмын төслийг боловсруулан батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сангийн яамтай хамтран байгуулах тухай албан бичгийг 2018 оны 1/152 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны А/16 тоот тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн гишүүдэд холбогдох журмын төсөл, материалуудын хамтаар мэйлээр хүргүүлж журмын саналыг нэгтгэлээ.</p> <p>Гэвч Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах боломжтой гэж Сангийн яамнаас хариу мэдэгдсэн. Иймд тусдаа журам гарах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>"Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам", суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ 2019 онд Засгийн газрын 12 дугаар тогтоолоор 100.0 мян.төг, 2020 онд 44 дүгээр тогтоолоор 200.0 мян.төгрөг болж шинэчлэгдэн батлагдсан.</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны төсөвт суралцагсадад сар тутам олгох тэтгэлэг 41.0 тэрбум төгрөг тусгагдаж давхардсан тоогоор 185,883 суралцагчдад 18.6 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон.</p> <p>2020 оны төсөвт 79.9 тэрбум төгрөг тусгагдаж эхний 4 дүгээр сарын байдлаар 2019 оны 12 дугаар сарын тэтгэлэгт 27,871 суралцагчийн 2.8 тэрбум төгрөг, 2020 оны 1-3 дугаар сарын тэтгэлэгт давхардсан тоогоор 67,191 суралцагчдад 13.4 тэрбум төгрөгийн тэтгэлгийг тус тус олгоод байна. Өмнөх жилүүдэд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдын тэтгэлгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр олгож байсан бол 2020 онд улсын төсвөөс 8.7 тэрбум төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 71.2 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөөд байна.</p> <p>Жил бүрийн төсөвт МБС-ын байгууллагад суралцаж буй суралцагчдыг сурах бичгээр хангах, шаардлагатай санхүүжилтийг сургалтын байгууллагын төсөвт хүүхдийн тооноос нь хамаарч тусгаж сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа.</p> <p>2019-2020 оны хичээлийн жилээс Ерөнхий боловсролын суралцагчдын сурах бичгийг зөвхөн сургуулийн номын сангаар дамжуулж ашиглуулахаар болсон тул төрийн өмчийн 37 МБС-ын харьяа байгууллага дүүрэг, аймгийн БСГ-аар дамжуулан номын сангаар дамжуулан ашиглуулах арга хэмжээ давхар авч байна.</p>
15	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх	<p>1.3/. Улсын дуурь, бүжгийн эрдмийн театр, Улсын драмын эрдмийн театрын материаллаг баазыг</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан 40.0 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр УИХ-аар соёрхон батлуулсан. Уг</p>

	<p>зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21</p>	<p>бэхжүүлэх, музейн камержуулалт, үзмэрийн бүртгэл, ном, судрын хадгалалтад шаардлагатай зардал, Соёлын өвийн үндэсний төв, Үндэсний номын сангийн барилгын ажлыг дуусгах, Үндэсний урлагийн их театр, Байгалийн түүхийн музей, Археологийн чиглэлийн музей, Хүүхдийн төв номын сангийн шинэ барилга барих хөрөнгө оруулалтыг улсын төсвийн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс жил бүр үе шаттай санхүүжүүлэх;</p>	<p>хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 130 дугаар тогтоолоор Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл, Үндэсний урлагийн их театрт тайз, дуу авианы тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, Хорт хавдрын навигаци болон стереотактик эмчилгээний төв байгуулах төсөл, Цэргийн төв эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл төслийг тус тус хэрэгжүүлэхээр баталсан. Төслүүдийн саналыг 2020 оны 5 дугаар сарын 2-ны тусгай үүргийн нислэгээр австрийн талд хүргүүлсэн. Австрийн тал дээрх төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл гүйцэтгэгч сонгон шалгаруулах</p>
16	<p>“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийг нэмэгдүүлэн 7 жил болгосон нь тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хөндөж байгаа талаар санал,</p>	<p>1. Хуулийн заалтын салаа утгыг нэг мөр шийдвэрлэх зорилгоор үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн тусгай албан хаагчид тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг нийт цалин хөлснөөс тооцон олгож байхаар Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>2. Мэргэшсэн алба хаагчдыг ажлын байранд нь урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “... цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд олгох 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нийт цалин хөлснөөс тооцох” талаар ажилтан, алба хаагчдыг зөв мэдээллээр хангаж ажиллахыг дээрх байгууллагуудад үүрэг болгох;</p> <p>3. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын өндөр</p>	<p>Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 4.1-д “Төрийн тусгай албан хаагчид Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр, мөн хуулийн 19.1-19.3 дахь хэсэгт заасан нэг удаагийн тэтгэмж олгоход “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам”-ыг баримтална.” мөн журмын 4.4-т “Хэрэв Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад нь зориулж нэг удаагийн тэтгэмж олгох талаар заасан бол төрийн албан хаагч тэдгээр тэтгэмжийн аль илүүг сонгох эрхтэй ба энэ тохиолдолд тэтгэмжийг давхардуулан олгохгүй.” гэж зааснаар төрийн тусгай албан хаагч аль илүү тэтгэмжийг сонгох эрхтэй. Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан журамд тусгагдсан.</p> <p>“Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам” хуулийн нэгдсэн портал сайтаар нийтэд мэдээлэгдэж байна. Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан журамд тусгагдсан.</p> <p>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн баталсан.</p>

<p>дүгнэлт шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцсэний дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай” хуралдааны тэмдэглэл 2018.10.16 №06</p>	<p>насны тэтгэвэртэй холбоотой асуудлыг тусгайлан авч үзэж, арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт даалгах;</p>	<p>Уг хуулиар Цэргийн алба хаагчийн тэтгэврийг тооцохдоо 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т хувааж тооцож байсныг “5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” хувааж тооцохоор болсон.</p>
	<p>4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг хэрэгжүүлэхдээ тэтгэвэр авагчийн тэтгэврийг бууруулахгүй байх зорилгоор тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар Засгийн газарт даалгах.</p>	<p>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн баталсан.</p> <p>Уг хуулиар Цэргийн алба хаагчийн тэтгэврийг тооцохдоо 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т хувааж тооцож байсныг “5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” хувааж тооцохоор болсон.</p>
<p>Нийт 16 тогтоолын 61 заалт</p>		

---o0o---

Танилцуулга бэлтгэсэн:
ХШҮХ-ийн референт

М.Мөнхзаяа

